ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ
СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ ТАНДАЛТ
СУДАЛГААНЫ АЛБА

ОСОЛ ГЭМТЛИЙН ТАНДАЛТЫН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2020 ОН

Хянасан: Б.Түмэн-Өлзий /Албаны дарга,
мэдээлэл зүйн мэргэжилтэн, АУ-ны докторант/

Тайлан боловсруулсан: А.Жаргалмаа /Албаны
эпидемиологич, НЭМ-ийн магистрант/

Б.Баянзул /Албаны НЭМ-ийн мэргэжилтэн/

Х.Мөнхзул /Албаны эпидемиологич/

ГССҮТӨВ СТАТИСТИК ТАНДАЛТ СУДАЛГААНЫ АЛБА
2021 он

ГАРЧИГ

- Товчилсон үгийн жагсаалт
- Үзүүлэлт тооцох аргачлал

БҮЛЭГ 1

- 2020 оны осол гэмтлийн шалтгаант өвчлөлийн байдалд хийгдсэн дүн шинжилгээ

БҮЛЭГ 2

- 2020 оны осол гэмтлийн шалтгаант нас баралтын байдалд хийгдсэн дүн шинжилгээ

БҮЛЭГ 3

- Харилцагч эрүүл мэндийн байгууллагуудын тандалтын мэдээ, тайлангийн үнэлгээ
- Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын бүртгэл, цахим мэдээний сан, сарын мэдээ, жилийн эцсийн тайлантай холбоотой анхаарах зүйлс, нийтлэг гарч буй хүндрэл, алдааны тухай

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
СТСА	Статистик тандалт судалгааны алба
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭХЭМҮТ	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
УНТЭ	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
УХТЭ	Улсын хоёрдугаар төв эмнэлэг
УГТЭ	Улсын гуравдугаар төв эмнэлэг
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ШШҮХ	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн
МЯСЭ	Монгол-Японы сургалтын эмнэлэг
ЦТЭ	Цэргийн төв эмнэлэг
ТЗНЭ	Төмөр замын нэгдсэн эмнэлэг
ТТАХНЭ	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
ХАЯТТ	Хүлээн авах яаралтай тусламжийн тасаг
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БГДЭМТ	Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв
БЗДНЭМТ	Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв
СХДНЭМТ	Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв
СБДНЭМТ	Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв
ХУДНЭМТ	Хан уул дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв
ЧДНЭМТ	Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв
НаДЭМТ	Налайх дүүргийн эрүүл мэндийн төв
БнДЭМТ	Багануур дүүргийн эрүүл мэндийн төв
БхДЭМТ	Багахангай дүүргийн эрүүл мэндийн төв

ҮЗҮҮЛЭЛТ ТООЦСОН АРГАЧЛАЛ

1. Осол гэмтлийн өвчлөлийн тохиолдлын түвшинг (ТТ) тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн шинэ тохиолдлын тоог тухайн жилийн хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
2. Осол гэмтлийн тархалтын түвшинг тооцохдоо тайлангийн жилд осол гэмтлийн шалтгаанаар эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан нийт тохиолдлын тоог тухайн жилийн хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
3. Осол гэмтлийн шалтгаан тус бүрийн өвчлөлийн түвшинг тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн (ӨОУА-10 дагуу осол гэмтлийн шалтгаан тус бүрээр) осол гэмтлийн шинэ өвчлөлийн тоог тухайн жилийн хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
4. Осол гэмтлийн шалтгаант нас баралтын түвшинг тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант нас баралтын тохиолдлын тоог тухайн жилийн хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
5. Осол гэмтлийн үхлийн түвшинг тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант нас баралтын тохиолдлын тоог тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн өвчлөлийн тоонд харьцуулан, 1 000 гэмтэл тутамд тооцно.
6. Осол гэмтлийн шалтгаан бүрт нас баралтын түвшинг тооцохдоо тайлангийн жилд тухайн шалтгаанаар бүртгэгдсэн нас баралтыг тухайн жилийн хүн амд харьцуулан, 10 000 хүн амд тооцсон.
7. Осол гэмтлийн шалтгаант нас баралтын болон өвчлөлийн тархалтыг харуулахдаа тухайн аймаг, дүүрэгт бүртгэгдсэн тохиолдлыг тухайн аймаг дүүргийн хүн амд харьцуулан, 10 000 хүн амд тооцсон.

I БҮЛЭГ

2020 оны осол гэмтлийн шалтгаант өвчлөлийн байдалд хийсэн дүн шинжилгээ

МОНГОЛ УЛСЫН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛИЙН БАЙДАЛ 2020

1. Ерөнхий хэсэг

2020 онд Монгол улсын хэмжээнд 145497 осол гэмтлийн шинэ тохиолдол бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх оноос 7.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөн 10000 хүн амд ногдох осол гэмтлийн түвшин 42.6 тохиолдлоор буурсан байна.



Осол гэмтэлд өртсөн нийт тохиолдлын 61% нь эрэгтэй, 39% нь эмэгтэй байна.



2020 онд тохиолдлын түвшин эрэгтэйд 546.8, эмэгтэйд 339.5 байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэйд 59.9 тохиолдлоор, эмэгтэйд 25.8 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Осол гэмтлийн өвчлөлд эрчүүд эмэгтэйчүүдээс 1.5 дахин их өртөж байгаа үзүүлэлттэй байна.



Нийт шинэ тохиолдлын тоо эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсэнд 0-4 насанд (эрэгтэй 12.7%, эмэгтэй 15.6%) хамгийн өндөр, 65-69 насанд хамгийн бага бүртгэгдсэн байна.



2020 онд гэмтэж бүртгэгдсэн хүмүүсийн дундаж нас 28.1, стандарт хазайлт нь 19.5 байна. Хамгийн багадаа дөнгөж төрсөн нярай гэмтсэн байгаа бол хамгийн ахмад нь 102 настай хүн байна.

Age median	95% CI	Std.Dev	min	max	Std.Err
28.1	28.0-28.2	19.5	0	102	0.5

Осол гэмтлийн шалтгаант шинэ тохиолдлын тоо 2018-2020 онд 5 хүртэлх насанд хамгийн их байна. Харин 10 000 хүн амд ногдох осол гэмтлийн шалтгаант тохиолдлын түвшин 2018 онд 25-29 насанд /536.1/, 2019 онд 20-24 насанд /541.0/, 2020 онд 0-4 насанд /523.5/ бусад наснаас өндөр байна. 2020 онд осол гэмтлийн шинэ тохиолдол 5-аас дээш бүх насанд буурсан үзүүлэлттэй байна. Харин 0-4 насанд жил бүр өсөх хандлага ажиглагдаж байна.

Насны бүлэг	2018 он		2019 он		2020 он	
	Тохиолдлын тоо	10 000 хүн амд	Тохиолдлын тоо	10 000 хүн амд	Тохиолдлын тоо	10 000 хүн амд
0-4	***18199***	467.6	***19738***	504.6	***20189***	***523.5***
5-9	12423	349.0	13854	386.6	12947	347.1
10-14	10830	433.1	13008	515.1	10833	387.9
15-19	10806	481.3	12224	535.2	9830	440.7
20-24	12182	513.8	13252	***541.0***	11611	484.6
25-29	15167	***536.1***	15357	521.4	13387	482.6
30-34	14272	498.3	15644	530.1	14807	485.9
35-39	10907	458.0	11760	481.5	11358	451.3
40-44	9145	420.9	10214	460.3	9530	425.1
45-49	7702	408.4	8483	442.3	8130	410.4
50-54	6992	429.3	7437	452.9	7231	436.5
55-59	5495	405.4	6089	449.2	5974	419.5
60-64	3463	391.9	3915	446.0	4115	426.7
65-69	1938	382.8	2189	435.1	2113	382.2
70+	3144	399.3	3559	458.4	3442	428.6

2020 онд осол гэмтэлд өртөж гэмтсэн нийт хүмүүсийн 45.8% нь дунд боловсролтой, 26.5% нь боловсролгүй, 14.1% дээд боловсролтой, 9.6% бага боловсролтой, 4.1% мэргэжил техникийн боловсролтой байна. Мөн осол гэмтэлд өртсөн 3 хүн тутмын 1 нь 0-15 насны хүүхэд, 2-3 нь ажилгүй хүн байна. Нийт гэмтсэн хүмүүсийн 29% нь */ажилчин, албан хаагч, малчин, бусад/* эрхэлсэн ажилтай иргэн байна.

2020 онд бүртгэгдсэн нийт осол гэмтлийн тохиолдлын 10.8% буюу 15764 нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмтсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 2.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмтсэн тохиолдол 30-34 насанд бусад наснаас өндөр бүртгэгдсэн байна.





2020 ОНЫ ОСОЛ ГЭМТЛИЙН ШИНЭ ТОХИОЛДЛЫН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН:



2020 онд бүртгэглсэн осол гэмтлийн шинэ тохиолдол эрэгтэй, эмэгтэй альч хүйсэнд Уналтын шалтгаан тэргүүлж байна.

Осол гэмтлийн шалтгаан	**Бодит тоо** /n=145497/		**Тохиолдлын түвшин 10 000 хүн амд**	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Уналт W00-W19	32149	28375	198.5	169.2
Амьгүй механик хүчинд өртөх W20-W49	18038	7764	111.4	46.3
Хүчирхийлэл X85-W09	10291	3882	63.5	23.1
Зам тээврийн осол V00-V99	12106	6200	74.7	37.0
Амьтай механик хүчинд өртөх W50-W64	6322	3975	39.0	23.7
Түлэгдэлт W85-X19	3564	3200	22.0	19.1
Шалтгаан тодорхойгүй осол	2959	1993	18.3	11.9
Санамсаргүй хордох, хорт бодист өртөх X40-X49	1247	787	7.7	4.7
Амиа хорлох X60-X84	752	320	4.6	1.9
Байгалийн хүчинд өртөх X30-X39	419	113	2.6	0.7
Бусад X50-X59, Y35-Y99	406	200	2.5	1.2
Амьсгал боох аюултай бусад осол W75-W84	139	73	0.9	0.4
Усанд живэх W65-W74	120	30	0.7	0.2
Хортой амьтан ургамалд өртөх X20-X29	42	31	0.3	0.2
Нийт	**88554**	**56943**	**546.8**	**339.5**

Түүнчлэн насны бүлгээс хамааран осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан өөр өөр байдаг. Жишээ нь: Бүх насанд уналт 1-р шалтгаан болж байна. Мөн 5 хүртэлх насанд түлэгдэлт, 5-9, 15-24, 30-49 болон 70+ насанд амьгүй механик хүчинд өртөх 2-р шалтгаан болж байгаа бол 25-39 насанд хүчирхийлэл, 10-14, 50-69 насанд зам тээврийн осол дэд байрт орж байна. Түүнчлэн 5 хүртэлх нас болон 65-аас дээш насанд шалтгаан тодорхойгүй осол гэмтэл 5-рт орж байна.

Насны бүлэг	Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаан				
	I	II	III	IV	V
0-4 нас n=20189	Уналт 44.9%	Түлэгдэлт 17.9%	Амьгүй механик хүчинд өртөх 14.4%	Амьд механик хүчинд өртөх 10.5%	Тодорхойгүй 6.7%
5-9 нас n=12947	Уналт 53.1%	Амьгүй механик хүчинд өртөх 16.3%	Зам тээврийн осол 10.5%	Амьд механик хүчинд өртөх 10.5%	Түлэгдэлт 4.4%
10-14 нас n=10833	Уналт 49.3%	Зам тээврийн осол 16.4%	Амьгүй механик хүчинд өртөх 15.2%	Амьд механик хүчинд өртөх 10.6%	Хүчирхийлэл 2.8%
15-19 нас n=9830	Уналт 39.8%	Амьгүй механик хүчинд өртөх 19.9%	Зам тээврийн осол 16.2%	Хүчирхийлэл 9.1%	Амьд механик хүчинд өртөх 8.1%
20-24 нас n=11611	Уналт 32.4%	Амьгүй механик хүчинд өртөх 23.2%	Зам тээврийн осол 15.9%	Хүчирхийлэл 14.5%	Амьд механик хүчинд өртөх 6.3%
25-29 нас n=13387	Уналт 31.9%	Хүчирхийлэл 21.7%	Амьгүй механик хүчинд өртөх 18.2%	Зам тээврийн осол 14.2%	Амьд механик хүчинд өртөх 5.5%
30-34 нас n=14807	Уналт 33.8%	Амьгүй механик хүчинд өртөх 20.6%	Хүчирхийлэл 17.8%	Зам тээврийн осол 13.6%	Амьд механик хүчинд өртөх 4.9%
35-39 нас n=11358	Уналт 33.2%	Амьгүй механик хүчинд өртөх 21%	Хүчирхийлэл 17.2%	Зам тээврийн осол 14.5%	Амьд механик хүчинд өртөх 4.8%
40-44 нас n=9530	Уналт 34.6%	Амьгүй механик хүчинд өртөх 19.9%	Хүчирхийлэл 15.2%	Зам тээврийн осол 14.5%	Амьд механик хүчинд өртөх 5.1%
45-49 нас n=8130	Уналт 38.6%	Амьгүй механик хүчинд өртөх 17.1%	Зам тээврийн осол 14.8%	Хүчирхийлэл 13.3%	Амьд механик хүчинд өртөх 5.2%
50-54 нас n=7231	Уналт 43.3%	Зам тээврийн осол 14.9%	Амьгүй механик хүчинд өртөх 14.9%	Хүчирхийлэл 10.5%	Амьд механик хүчинд өртөх 5.2%
55-59 нас n=5974	Уналт 49.1%	Зам тээврийн осол 13.5%	Амьгүй механик хүчинд өртөх 13.4%	Хүчирхийлэл 8.2%	Амьд механик хүчинд өртөх 5.7%
60-64 нас n=4115	Уналт 55.5%	Зам тээврийн осол 12.4%	Амьгүй механик хүчинд өртөх 11.8%	Амьд механик хүчинд өртөх 5.9%	Хүчирхийлэл 4.9%
65-69 нас n=2113	Уналт 60.9%	Зам тээврийн осол 11.2%	Амьгүй механик хүчинд өртөх 9.4%	Амьд механик хүчинд өртөх 5.8%	Хүчирхийлэл 3.6%
70+ нас n=3442	Уналт 70.6%	Амьгүй механик хүчинд өртөх 7.9%	Зам тээврийн осол 6.8%	Амьд механик хүчинд өртөх 4.1%	Тодорхойгүй осол 3.5%

2020 онд бүртгэгдсэн нийт осол гэмтэлд өртсөн 22.3% нь толгойн гэмтлийн оноштой байна. Мөн 30.9% нь дээд мөчдийн гэмтэл, 24.1% нь доод мөчдийн гэмтлийн үндсэн оноштой байна.



Бусад гэмтлийн эзлэх хувь

Гэмтлийн байршил	Хувь
Түлэгдэлт /T20-T32/	4.7%
Бусад тодорхойгүй хэсгийн гэмтэл /T10-T14/	2.9%
Эмийн бус бэлдмэлийн хордлого /T51-T65/	1.3%
Биеийн олон хэсгийн гэмтэл /T00-T09/	1.0%
Биеийн сүвээр орсон гадны биетийн гэмтэл /T15-T19/	0.7%
Бусад тодорхойгүй нөлөөлөл /T66-T78/	0.7%
Хөлдөлт /T33-T35/	0.2%
Эм биологийн бэлдмэлийн хордлого /T36-T50/	0.1%

Гэмтлийн оношийн төрлөөр 28.6% нь зөөлөн эдийн гэмтэлтэй, 21.5% нь ямар нэг эрхтний шархтай байгаа бол 20.9% нь аль нэг ясны хугарлын оноштой байна.



Осол гэмтлийн шинэ тохиолдлын 31% нь зун, 25% нь намрын улиралд бүртгэгдсэн байна.



2020 онд осол гэмтлийн шалтгаант өвчлөл 7 сард 10.6% буюу хамгийн их, 12 сард хамгийн бага буюу 5.4% бүртгэгдсэн байна.



2020 онд бүртгэгдсэн нийт ослын 82.6% нь буюу 120182 тохиолдол нь нийслэлд 17.4% нь орон нутагт бүртгэгджээ. 10000 хүн тутамд нийслэлд 780 хүн, орон нутагт 144 хүн гэмтсэн байна. Осол гэмтлийн шинэ тохиолдлын тоо өмнөх оноос нийслэлд 11702 тохиолдлоор буурсан байгаа бол орон нутагт 477 тохиолдлоор өсжээ.



10000 хүн амд тохиолдох тохиолдлын түвшин Дорноговь, Говьсүмбэр, Говь-Алтай аймагт өндөр, Орхон, Ховд, Баян-Өлгий аймагт бага байна.



Түүнчлэн аймаг бүрт осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан харилцан адилгүй байна. 2020 онд 18 аймагт түлэгдэлтийн шалтгаант осол гэмтэл тэргүүлэх шалтгааны 4 болон 5-рт бүртгэгдсэн байна.

Аймгийн нэр	**Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаан**				
	I	**II**	**III**	**IV**	**V**
Архангай **n=1904**	ЗТО 36.2%	Хүчирхийлэл 17.4%	Уналт 16.3%	Амьгүй м/х өртөх 11.8%	Амьтай м/х өртөх 6.7%
Баян-Өлгий **n=792**	Уналт 55.7%	ЗТО 18.3%	Амьгүй м/х өртөх 9.5%	Түлэгдэлт 6.6%	Амьтай м/х өртөх 5.0%
Баянхонгор **n=1281**	Уналт 34.8%	ЗТО 26.9%	Амьгүй м/х өртөх 10.1%	Хүчирхийлэл 10.1%	Түлэгдэлт 8.2%
Булган **n=650**	ЗТО 36.5%	Уналт 16.2%	Хүчирхийлэл 14.8%	Амьгүй м/х өртөх 13.1%	Түлэгдэлт 9.1%
Говь-Алтай **n=1279**	ЗТО 33.3%	Уналт 28.5%	Амьгүй м/х өртөх 12.8%	Түлэгдэлт 8.1%	Хүчирхийлэл 7.3%
Говьсүмбэр **n=520**	Уналт 29.2%	Амьгүй м/х өртөх 21.7%	ЗТО 20.4%	Түлэгдэлт 8.3%	Амьтай м/х өртөх 8.1%
Дархан-уул **n=1587**	Уналт 62.3%	Амьгүй м/х өртөх 12.9%	Хүчирхийлэл 9.1%	ЗТО 5.9%	Түлэгдэлт 4.7%
Дорноговь **n=2890**	Уналт 29.8%	Амьгүй м/х өртөх 21.1%	ЗТО 18.2%	Хүчирхийлэл 16.7%	Түлэгдэлт 5.4%
Дорнод **n=1251**	Уналт 30.1%	ЗТО 25.0%	Амьгүй м/х өртөх 16.7%	Хүчирхийлэл 9.5%	Түлэгдэлт 8.9%
Дундговь **n=869**	ЗТО 34.6%	Уналт 19.9%	Хүчирхийлэл 15.9%	Амьгүй м/х өртөх 12.1%	Амьтай м/х өртөх 6.7%
Завхан **n=987**	ЗТО 35.4%	Уналт 18.2%	Амьгүй м/х өртөх 16.0%	Амьтай м/х өртөх 9.5%	Түлэгдэлт 7.6%
Орхон **n=857**	Уналт 38.9%	ЗТО 21.2%	Амьгүй м/х өртөх 18.6%	Түлэгдэлт 8.7%	Хүчирхийлэл 4.4%
Өвөрхангай **n=1054**	Уналт 28.6%	ЗТО 26.9%	Амьгүй м/х өртөх 16.3%	Хүчирхийлэл 8.1%	Амьтай м/х өртөх 7.8%
Өмнөговь **n=1479**	ЗТО 30.5%	Амьгүй м/х өртөх 24.1%	Уналт 15.1%	Хүчирхийлэл 12.6%	Түлэгдэлт 7.7%
Сүхбаатар **n=682**	ЗТО 36.5%	Уналт 20.8%	Амьгүй м/х өртөх 11.9%	Хүчирхийлэл 8.9%	Түлэгдэлт 8.5%
Сэлэнгэ **n=1132**	Уналт 21.6%	Хүчирхийлэл 19.5%	Амьгүй м/х өртөх 19.4%	ЗТО 18.6%	Амьтай м/х өртөх 7.3%
Төв **n=1683**	Уналт 31.3%	ЗТО 25.6%	Амьгүй м/х өртөх 16.2%	Хүчирхийлэл 10.1%	Түлэгдэлт 6.6%
Увс **n=843**	ЗТО 32.7%	Амьгүй м/х өртөх 20.2%	Уналт 18.9%	Түлэгдэлт 10.3%	Хүчирхийлэл 7.4%
Ховд **n=710**	Уналт 36.8%	ЗТО 23.9%	Амьгүй м/х өртөх 10.9%	Түлэгдэлт 10.3%	Хүчирхийлэл 9.3%
Хөвсгөл **n=1416**	ЗТО 29.0%	Амьгүй м/х өртөх 16.3%	Хүчирхийлэл 14.8%	Уналт 14.3%	Түлэгдэлт 8.1%
Хэнтий **n=1449**	Уналт 26.0%	ЗТО 25.3%	Амьгүй м/х өртөх 18.5%	Хүчирхийлэл 10.2%	Түлэгдэлт 8.4%

2020 онд осол гэмтлийн тохиолдлын түвшин Төвийн бүсэд өндөр байна.



Осол гэмтэлд өртсөн нийт тохиолдлын 39.3% нь гэртээ, 31.4% нь гудамж замд гэмтсэн байна.

2020 онд осол гэмтэлд өртсөн нийт тохиолдлын 88% нь эрүүл мэндийн байгууллагад өөрөө, 10.2% нь түргэн тусламжаар, 1.8% нь такси болон бусад зүйлээр эмнэлэгт ирсэн байна.



1.1. УНАЛТЫН ШАЛТГААНТ ОСОЛ ГЭМТЛИЙН ШИНЭ ТОХИОЛДОЛ /W00-W19/

Улсын хэмжээнд 2020 онд уналтын шалтгаант 60524 шинэ тохиолдол бүртгэгдэж, осол гэмтлийн өвчлөлийг тэргүүлсэн хэвээр байна. Уналтын шалтгаант өвчлөлийн 10000 хүн амд ногдох тохиолдлын түвшин 183.6 байгаа ба өмнөх оноос 6.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



2020 онд унаж гэмтсэний улмаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчдийн 53.1%-ийг эрэгтэйчүүд, 46.9%-ийг эмэгтэйчүүд эзэлжээ. 10000 хүн ам тутам ногдох тохиолдлын түвшин эрэгтэйчүүдэд эмэгтэйчүүдээс 29-30 тохиолдлоор их байна.



Уналтын шалтгаант өвчлөлийг насны бүлгээр авч үзэхэд тохиолдлын тоогоор 0-4 насны хүүхдэд их байгаа бол тохиолдлын түвшин 70-с дээш насанд хамгийн өндөр байна. Өөрөөр хэлбэл 70-с дээш настай 10000 хүн тутмын 302.7 нь унаж гэмтэж байна.



Бүх насны бүлэгт нэг түвшин дээр, хальтирч тээглэж бүдэрч ойчих /W01/ төрлийн уналт тэргүүлсэн байна.

Насны бүлэг	Уналтын шалтгаант өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, насны бүлгээр 2020				
	I	II	III	IV	V
0-4	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 45.4%	Орноос ойчих 22.5%	Сандлаас ойчих 5.5%	Бусад тавилгаас ойчих 4.9%	Тоглоом ба спортын талбай 4.8%
5-9	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 42.0%	Тоглоом ба спортын талбай 17.4%	Тэшүүр, цана, чарганаас ойчих 7.7%	Орноос ойчих 7.6%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.7%
10-14	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 51.6%	Тоглоом ба спортын талбай 12.5%	Шат гишгүүрээс ойчих 7.9%	Тэшүүр, цана, чарганаас ойчих 7.8%	Хүнтэй мөргөлдөх, түлхэгдэн ойчих 4.0%
15-19	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 57.5%	Шат гишгүүрээс ойчих 10.8%	Тоглоом ба спортын талбай 6.1%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 6.0%	Хүнтэй мөргөлдөх, түлхэгдэн ойчих 5.4%
20-24	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 55.0%	Шат гишгүүрээс ойчих 15.9%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 7.3%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.4%	Хүнтэй мөргөлдөх, түлхэгдэн ойчих 4.0%
25-29	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 52.8%	Шат гишгүүрээс ойчих 16.8%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 9.1%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.3%	Хүнтэй мөргөлдөх, түлхэгдэн ойчих 3.8%
30-34	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 50.8%	Шат гишгүүрээс ойчих 17.1%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 9.9%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 6.9%	Барилга, байгууламжаас ойчих 4.3%
35-39	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 49.6%	Шат гишгүүрээс ойчих 17.5%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 11.0%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 7.6%	Барилга, байгууламжаас ойчих 4.0%
40-44	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 51.8%	Шат гишгүүрээс ойчих 17.5%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 10.9%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 7.2%	Барилга, байгууламжаас ойчих 4.6%
45-49	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 51.5%	Шат гишгүүрээс ойчих 17.5%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 11.9%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 6.5%	Барилга, байгууламжаас ойчих 3.5%
50-54	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 53.9%	Шат гишгүүрээс ойчих 15.8%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 13.8%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.3%	Барилга, байгууламжаас ойчих 3.0%
55-59	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 55.8%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 14.6%	Шат гишгүүрээс ойчих 14.0%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 4.2%	Барилга, байгууламжаас ойчих 2.7%
60-64	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 59.8%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 13.6%	Шат гишгүүрээс ойчих 12.6%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 4.3%	Сандлаас ойчих 3.0%
65-69	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 62.9%	Шат гишгүүрээс ойчих 13.5%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 9.9%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 3.1%	Сандлаас ойчих 3.4%
70+	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 68.4%	Шат гишгүүрээс ойчих 9.4%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 7.6%	Сандлаас ойчих 4.5%	Орноос ойчих 4.2%

2020 онд нийт унаж гэмтсэн тохиолдлын 18.9 хувь нь тохой ба шууны гэмтэл, 18.5% нь шагай ба тавхайн гэмтэл, 15.8% нь толгойн гэмтлээр тус тус оношлогдсон байна.



Гэмтлийн онош	Тохиолдлын тоо	Хувь
Тохой ба шууны гэмтэл /S50-S59/	***11424***	18.9
Шагай ба тавхайн гэмтэл /S90-S99/	***11214***	18.5
Толгойн гэмтэл /S00-S09/	***9569***	15.8
Өвдөг ба шилбэний гэмтэл /S80-S89/	8197	13.5
Бугуй ба сарвууны гэмтэл /S60-S69/	4111	6.8
Мөр ба бугалгын гэмтэл /S40-S49/	4393	7.3
Хэвлий, зоо нуруу, ууц ба аарцгийн гэмтэл /S30-39/	3602	6.0
Цээжний гэмтэл /S20-S29/	3457	5.7
Түнх ба гуя орчмын гэмтэл /S70-S79/	2486	4.1
Их бие , мөч буюу биеийн бүсийн тодорхойгүй хэсгийн гэмтэл /T10-T14/	1497	2.5
Хүзүүний гэмтэл /S10-S19/	312	0.5
Биеийн олон хэсгийг хамарсан гэмтэл /T00-T09/	262	0.4
Нийт	**60524**	100%

Нийт унаж гэмтсэн тохиолдлын 5.0% нь гэмтэх үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн байсан ба осол гарах үеийн байршлаар авч үзвэл 42% нь гэртээ, 30% нь гудамж замд гэмтсэн байна.



2020 онд тус өвчлөлийн 30.0% нь зуны улиралд бүртгэгдсэн байна.



2020 оны уналтын шалтгаант өвчлөлийн 88.1% нь нийслэлд 11.9% нь орон нутагт бүртгэгджээ. Нийслэлийн 10000 хүн ам тутам ногдох тохиолдлын түвшин өмнөх оноос 38 тохиолдлоор буурсан байгаа бол хөдөө орон нутагт тухайн газар нутгийн 10000 хүн амд ногдох тохиолдлын түвшин өмнөх онтой харьцуулахад ижил буюу 40.8 байна.



1.2. ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ /V01-V99/

2020 онд зам тээврийн ослын шалтгаанаар 17816 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 15.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Зам тээврийн ослын улмаас энэ онд 10000 хүн ам тутамд 54.0 хүн гэмтжээ. Энэ нь 2019 оноос тохиолдлын түвшин 10.8 тохиолдлоор буурсан үзүүлэлт юм.



34.2% Эмэгтэй

Зам тээврийн ослын шалтгаанаар эмнэлэгт хандсан байдал хүйсээр:

65.8% Эрэгтэй

Зам тээврийн ослоор 10000 хүн тутамд 72.4 эрэгтэй, 36.3 нь эмэгтэйчүүд гэмтсэн байгаа нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.9 дахин их зам тээврийн осолд өртөмхий байгааг илтгэж байна.



Зам тээврийн осолд өртсөн хүмүүсийг насны бүлгээр судлахад 10000 хүн тутамд ногдох тохиолдлын түвшин 20-24 насанд хамгийн өндөр, 5 хүртэлх насанд хамгийн бага байна. Мөн 2020 онд дийлэнх насанд буурсан үзүүлэлттэй байна.



2020 онд зам тээврийн ослын улмаас эмнэлэгт хандсан тохиолдлын тоо эрэгтэй хүйсэнд 25-29 насанд, эмэгтэй хүйсэнд 30-34 насанд хамгийн их байгаа бол аль ч хүйсэнд 65-аас дээш насанд осол гэмтэл хамгийн бага бүртгэгдсэн байна.



Зам тээврийн ослын шалтгаанаар эмнэлэгт хандсан иргэдийн тохиолдлын түвшинг насны бүлэг бүрт хүйсээр дараах хүснэгтээс харна уу.

Зам тээврийн ослын шалтгаант өвчлөл, насны бүлэг, хүйсээр 10000 хүн амд						
Насны бүлэг	2018		2019		2020	
0-4	25.9	22.1	23.3	19.7	20.4	14.8
5-9	55.1	30.3	60.0	29.9	50.2	21.2
10-14	86.4	39.1	102.9	37.8	92.0	33.1
15-19	84.8	57.3	93.7	56.7	97.4	43.6
20-24	103.4	68.9	109.1	63.6	96.9	54.3
25-29	107.8	60.8	99.4	57.6	84.9	47.7
30-34	98.2	57.8	95.6	58.1	84.9	44.6
35-39	100.4	55.5	100.0	57.4	83.9	43.4
40-44	93.5	52.1	98.8	53.6	78.8	42.2
45-49	91.8	55.2	96.1	49.1	79.6	37.8
50-54	95.7	55.7	99.1	56.1	87.6	41.2
55-59	90.2	53.2	90.3	54.1	74.2	37.6
60-64	80.5	44.9	79.3	46.2	68.4	36.1
65-69	59.4	38.0	84.0	40.7	51.7	33.1
70+	55.4	26.8	52.1	31.2	35.9	21.6
Нийт	80.6	47.5	83.4	46.7	72.4	36.3

Зам тээврийн осол бүртгэгдсэн харьяаллаар: Зам тээврийн ослын улмаас эмнэлэгт хандсан иргэдийн 65.1% нь нийслэлд, 34.9% нь орон нутагт бүртгэгдсэн байна.



Насны бүлэг бүрт тээврийн хэрэгслийн төрөл статистик ач холбогдол бүхий ялгаатай байна. 5 хүртэлх болон 15 дээш насанд суудлын машинд явж байх үедээ зам тээврийн осолд өртсөн тохиолдол хамгийн их бүртгэгдсэн байгаа бол 5-9 насанд явган явж байх үедээ тээврийн хэрэгсэлд мөргүүлж гэмтсэн тохиолдол 1-р шалтгаан болж байна. Ердийн хөсөг буюу морь, тэмээнээс унаж гэмтсэн тохиолдол 10-14 насанд 1-р байр, 5-9 насанд 2-р байрыг эзэлж байна. 60-аас дээш насанд нийтийн тээврийн хэрэгсэл дотор явж байх үедээ гэмтсэн тохиолдол цөөнгүй бүртгэгджээ.

Насны бүлэг	Тээврийн хэрэгслийн төрөл 2020 он				
	I	II	III	IV	V
0-4	V40-V49 54.6%	V00-V09 27.2%	V20-V39 5.6%	V10-V19 4.8%	V80-V89 3.5%
5-9	V00-V09 32.4%	V80-V89 21.7%	V40-V49 21.2%	V10-V19 16.1%	V20-V39 5.8%
10-14	V80-V89 33.1%	V10-V19 23.1%	V00-V09 15.4%	V40-V49 14.2%	V20-V39 12.8%
15-19	V40-V49 26.2%	V20-V39 23.9%	V00-V09 17.9%	V80-V89 17.6%	V10-V19 12.9%
20-24	V40-V49 44.7%	V20-V39 21.7%	V00-V09 17.8%	V80-V89 8.5%	V10-V19 4.1%
25-29	V40-V49 43.0%	V20-V39 24.2%	V00-V09 16.5%	V80-V89 9.3%	V50-V69 2.9%
30-34	V40-V49 41.3%	V20-V39 24.0%	V00-V09 16.4%	V80-V89 9.3%	V50-V69 3.7%
35-39	V40-V49 37.5%	V20-V39 28.1%	V00-V09 16.5%	V80-V89 11.2%	V50-V69 3.5%
40-44	V40-V49 35.5%	V20-V39 26.9%	V00-V09 20.5%	V80-V89 11.0%	V50-V69 3.6%
45-49	V40-V49 31.3%	V20-V39 25.8%	V00-V09 21.5%	V80-V89 13.3%	V50-V69 3.4%
50-54	V40-V49 28.8%	V20-V39 28.2%	V00-V09 21.9%	V80-V89 13.5%	V50-V69 3.0%
55-59	V40-V49 31.0%	V20-V39 23.2%	V00-V09 23.0%	V80-V89 13.8%	V50-V69 3.4%
60-64	V40-V49 26.1%	V00-V09 23.2%	V20-V39 20.9%	V80-V89 18.9%	V70-V79 4.6%
65-69	V40-V49 30.2%	V00-V09 28.9%	V20-V39 16.9%	V80-V89 13.3%	V70-V79 5.8%
70+	V40-V49 35.9%	V00-V09 30.4%	V80-V89 14.7%	V20-V39 9.2%	V70-V79 6.4%

Зам тээврийн ослын улмаас эмнэлэгт хандсан нийт тохиолдлын 10.8% нь осолд орох үедээ согтуурруулах ундаа хэрэглэсэн байсан гэсэн өгүүлэмжтэй байна.

Зам тээврийн ослын үед ачааны машинтай явж байгаад гэмтсэн иргэдийн 72.6%, суудлын машинтай явж байгаад гэмтсэн иргэдийн 59.0% нь хамгаалах бүс хэрэглээгүй байжээ.



Жил бүр 1500-2000 хүн согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зам тээврийн осолд өртөж байна. Өөрөөр хэлбэл 10000 хүн тутамд 5.3-7.3 хүн энэ шалтгаанаар эрүүл мэндийн байгууллагад ханджээ.



Явганаар болон унадаг дугуй, автобусаар явж байхдаа зам тээврийн осолд орсон тохиолдлуудад тархины гэмтэл, суудлын болон ачааны машинтай явж байхдаа осолд орсон тохиолдлуудад биеийн олон хэсгийн гэмтэл, ердийн хөсөгтэй явж байгаад осолд орсон тохиолдлуудад цээжний гэмтэл тэргүүлж байна.

Гэмтлийн онош	Зам тээврийн ослын шалтгаан				
	I	II	III	IV	V
Тархины гэмтэл (S00-S09)	V40-V49 45.4%	V20-V39 21.3%	V01-V09 15.4%	V80-V80.9 4.8%	V10-V19 3.9%
Хүзүүний гэмтэл (S10-S19)	V40-V49 63.9%	V20-V39 16.2%	V80-V80.9 8.2%	V01-V09 5.3%	V50-V69 3.2%
Цээжний гэмтэл (S20-S29)	V40-V49 40.5%	V20-V39 23.2%	V80-V80.9 17.0%	V01-V09 10.7%	V50-V69 3.8%
Хэвлийн гэмтэл (S30-S39)	V40-V49 40.8%	V01-V09 23.6%	V20-V39 12.7%	V80-V80.9 12.1%	V10-V19 3.9%
Мөр ба бугалгын гэмтэл (S40-S49)	V80-V80.9 32.1%	V20-V39 31.1%	V40-V49 17.6%	V01-V09 8.3%	V10-V19 7.7%
Тохой ба шууны гэмтэл (S50-S59)	V80-V80.9 27.7%	V10-V19 22.8%	V20-V39 18.4%	V01-V09 15.2%	V40-V49 12.1%
Бугуй ба сарвууны гэмтэл (S60-S69)	V40-V49 21.9%	V10-V19 21.1%	V01-V09 18.2%	V20-V39 17.3%	V80-V80.9 15.6%
Түнх ба гуяны гэмтэл (S70-S79)	V01-V09 29.6%	V20-V39 23.2%	V40-V49 19.1%	V80-V80.9 17.3%	V10-V19 7.3%
Өвдөг ба шилбэний гэмтэл (S80-S89)	V20-V39 32.8%	V01-V09 29.1%	V80-V80.9 16.1%	V40-V49 10.8%	V10-V19 8.0%
Шагай ба тавхайн гэмтэл (S90-S99)	V01-V09 56.2%	V20-V39 16.7%	V80-V80.9 10.2%	V10-V19 7.8%	V40-V49 7.2%
Биеийн олон хэсгийн гэмтэл (T00-T09)	V40-V49 54.8%	V01-V09 26.0%	V20-V39 7.5%	V10-V19 4.0%	V50-V69 3.0%
Бусад тодорхойгүй хэсгийн гэмтэл (T10-T14)	V40-V49 50.0%	V01-V09 27.4%	V80-V80.9 8.3%	V20-V39 7.8%	V10-V19 2.7%
Бусад тодорхойгүй нөлөөлөл (T66-T78)	V40-V49 100%				

2020 онд зам тээврийн ослын тэргүүлэх шалтгаанаар суудлын машин дотор явж байхдаа осолд орж гэмтсэн тохиолдол 33.6% -ийг эзэлж байна.

ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН



Зам тээврийн ослын улмаас зуны улиралд хамгийн их осол гэмтэл бүртгэгдсэн байна.



Зам тээврийн ослын шалтгаант өвчлөл Архангай аймагт хамгийн их бүртгэгдсэн ба тухайн газар нутгийн 10000 хүн амд ногдох зам тээврийн ослын түвшин Дорноговь болон Говь-Алтай аймагт өндөр байна. Харин зам тээврийн ослын тоо болон тохиолдлын түвшин Дархан-Уул аймагт хамгийн бага бүртгэгджээ.





1.3. АМЬГҮЙ МЕХАНИК ХҮЧИНД ӨРТӨХ ГЭМТЭЛ

Амьгүй механик хүчинд өртөж гэмтэх шалтгаанаар 2020 онд 25753 хүн эрүүл мэндийн байгууллагад хандсан байна. Энэ нь 10000 хүнд ногдох тохиолдлын түвшин 78.1 тохиолдол буюу өмнөх оноос буурсан үзүүлэлт юм.



2020 онд амьгүй механик хүчинд өртөх шалтгаанаар гэмтэж бүртгэгдсэн тохиолдол хүйсийн хувьд 69.9% /17996/ нь эрэгтэй, 30.1% /7757/ эмэгтэйчүүд эзэлж байна.



Амьгүй механик хүчинд өртөх шалтгаант өвчлөл 30-34 насанд тохиолдлын тоо өндөр байгаа бөгөөд насны бүлэг бүрт 10000 хүн тутамд ногдох тохиолдлын түвшин 20-24 насанд 112.6 тохиолдол буюу хамгийн өндөр байна.



2020 онд амьгүй механик хүчинд өртөж гэмтсэн нийт тохиолдлын 4.9% нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тухайн шалтгаанаар гэмтсэн байна. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ амьгүй механик хүчинд өртөж гэмтсэн тохиолдлын 84.1% эрэгтэй, 15.9% эмэгтэй байжээ.



Сүүлийн жилд амьгүй механик хүчинд өртөж бүртгэгдсэн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан 1-рт бусад зүйл мөргөх ба цохигдож гэмтэх /29.1%/-ийг эзэлж байна.

Амьгүй механик хүчинд өртөх тэргүүлэх 5 шалтгаан

Амьгүй механик хүчинд өртөх шалтгааныг насны бүлэг бүрт тэргүүлэх 5 шалтгаанаар авч үзэхэд бүх насанд бусад зүйл мөргөх буюу цохигдох 1-р шалтгаан болж байна. 2, 3, 4, 5-р шалтгаан насны бүлэг бүрт харилцан адилгүй ялгаатай байна.

Насны бүлэг	АМЬГҮЙ МЕХАНИК ХҮЧИНД ӨРТӨХ ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН				
	I	II	III	IV	V
0-4	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 47.1%	Хоёр юмны хооронд хавчигдах 16.6%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 10.4%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 6.6%	Хурц шилэнд зүсэгдэх 6.8%
5-9	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 42.6%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 13.5%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 12.0%	Хоёр юмны хооронд хавчигдах 10.4%	Хурц шилэнд зүсэгдэх 8.5%
10-14	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 37.3%	Спортын хэрэгсэл мөргөх цохигдох 12.6%	Хурц шилэнд зүсэгдэх 9.5%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 8.8%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 8.4%
15-19	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 29.4%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 10.8%	Хурц шилэнд зүсэгдэх 10.7%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 10.5%	Хоёр юмны хооронд хавчигдах 9.1%
20-24	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 24.4%	Хурц шилэнд зүсэгдэх 14.5%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 12.7%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 10.6%	Хоёр юмны хооронд хавчигдах 10.2%
25-29	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 23.9%	Хурц шилэнд зүсэгдэх 13.7%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 11.6%	Хутганд өртөх 10.9%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 10.7%
30-34	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 24.2%	Хурц шилэнд зүсэгдэх 14.1%	Хутганд өртөх 10.9%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 10.6%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 10.5%
35-39	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 24.6%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 11.8%	Хурц шилэнд зүсэгдэх 11.1%	Хутганд өртөх 11.1%	Гэр ахуйн хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртөх 10.9%
40-44	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 20.5%	Гэр ахуйн хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртөх 15.0%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 11.6%	Хутганд өртөх 10.1%	Хурц шилэнд зүсэгдэх 10.1%
45-49	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 22.6%	Гэр ахуйн хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртөх 16.5%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 10.3%	Хоёр юмны хооронд хавчигдах 9.8%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 9.4%
50-54	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 21.1%	Гэр ахуйн хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртөх 18.9%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 10.8%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 10.2%	Хоёр юмны хооронд хавчигдах 8.9%
55-59	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 23.8%	Гэр ахуйн хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртөх 17.0%	Хутганд өртөх 9.8%	Хоёр юмны хооронд хавчигдах 9.4%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 9.1%
60-64	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 24.3%	Гэр ахуйн хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртөх 17.2%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 10.4%	Хутганд өртөх 10.4%	Хурц шилэнд зүсэгдэх 6.8%
65-69	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 24.2%	Гэр ахуйн хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртөх 19.7%	Хоёр юмны хооронд хавчигдах 12.1%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 11.6%	Хутганд өртөх 9.6%
70+	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 30.1%	Гэр ахуйн хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртөх 14.1%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 9.7%	Хутганд өртөх 9.7%	Хоёр юмны хооронд хавчигдах 8.9%

Амьгүй механик хүчинд өртөх шалтгаант өвчлөл, улирлаар

2020 онд амьгүй механик хүчинд өртөх шалтгаанд өртөж гэмтсэн тохиолдлыг улирлаар авч үзэхэд зун 32.3% хамгийн их бүртгэгдсэн байна. Хавар, намрын улиралд 25.0% байсан бол өвлийн улиралд 17.7% хамгийн бага бүртгэгджээ.

Амьгүй механик хүчинд өртөх шалтгаанаар гэмтсэн тохиолдлуудыг бүртгэгдсэн газрын харьяаллаар авч үзэхэд нийслэлд 84.3%, орон нутагт 15.7% ийг эзэлж байна.



2020 онд амьгүй механик хүчинд өртөх шалтгаанаар эмнэлгийн тусламж авсан хүмүүсийн гэмтлийн оношийг байршлаар авч үзэхэд дараах гэмтлүүд хамгийн өндөр бүртгэгджээ. Үүнд амьгүй механик хүчинд өртөж гэмтсэн хүмүүс ихэвчлэн толгойн гэмтэл (18.8%) болон дээд доод мөчдийн гэмтлүүд (66.4%) байсан ба үлдсэн хувийг бусад гэмтлүүд эзэлж байна.

Амьгүй механик хүчинд өртөх шалтгаант өвчлөл, тэргүүлэх гэмтлийн онош



Амьгүй механик хүчинд өртөх шалтгаант өвчлөлийн тохиолдлын тоо 606, тохиолдлын түвшин 10000 хүн ам тутамд 85.3 тохиолдлоор тус тус Дорноговь аймагт өндөр байна.



2020 онд амьгүй механик хүчинд өртөх шалтгаанаар гэмтэж бүртгэгдсэн өвчлөлийг осол гарах үеийн байршлын хувиар авч үзэхэд хамгийн өндөр хувийг буюу 51.7% гэртээ, 12.1% гудамж, замд гэмтсэн байна.



1.4. “ХҮЧИРХИЙЛЭЛ”-ИЙН ШАЛТГААНТ ОСОЛ ГЭМТЛИЙН ТОХИОЛДОЛ /X85-Y09/

2020 онд монгол улсад дайралт, халдлагад өртөж гэмтсэн 14173 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь нийт тохиолдлын 9.7%-ийг эзэлж байна. Энэ нь өмнөх оноос 19.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хүчирхийллийн шалтгаант осол гэмтлийн тохиолдлын түвшин 10000 хүн тутамд 43.0



Хүчирхийлэлд өртсөн нийт тохиолдлын

72.6% нь эрэгтэй, 27.4% нь эмэгтэй

хүмүүс байна.

2020 онд хүчирхийллийн шалтгаанаар гэмтсэн тохиолдол өмнөх оноос эрэгтэйд 2919 тохиолдлоор, эмэгтэйд 588 тохиолдлоор буурсан байна. Мөн онд хүчирхийллийн шалтгаант осол гэмтэл 10000 хүн тутамд эрэгтэйд 63.5 тохиолдол, эмэгтэйд 23.1 тохиолдол байна. Хүчирхийллийн тохиолдол эрэгтэй хүйсэнд өндөр бүртгэгдсэн байна



Хүчирхийллийн шалтгаант өвчлөлийн тохиолдол эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсэнд 30-34 насанд өндөр бүртгэгдсэн байна.



Хүчирхийллийн шалтгаант тохиолдлын түвшин эрэгтэйд 25-29 насанд, эмэгтэйд 30-34 насанд бусад насны бүлгүүдээс өндөр байна.



Тухайн онд хүчирхийллийн шалтгаанаар гэмтсэн нийт 14173 иргэдийг хүчирхийллийн хэлбэрээр нь авч үзэхэд 98.4% нь бие махбодийн хүчирхийлэлд өртсөн байна.



Хүчирхийлэгч, хохирогч хоорондын холбоогоор нь судлахад 33.3% нь танил найздаа, 33.1% нь үл таних хүний халдлагад өртсөн байна.



Хүчирхийлэлд өртсөн хохирогчдын 76.1% /10791/ нь биеийн хүчээр халдах халдагад, 12.3% /1743/ нь иртэй зүйлээр халдах халдлагад өртсөн байна.



2020 онд хүчирхийллийн шалтгаанаар гэмтэж бүртгэгдсэн тохиолдол бүх насны бүлэгт ижил биеийн хүчээр халдах шалтгаан 1-р байгаа бол 15-59 насанд Иртэй зүйлээр халдах, 5-14 нас, 60-64 нас, мөн 70+ насанд мохоо зүйлээр халдах 2-р шалтгаан болж байна. III, IV, V шалтгаан нь насны бүлэг бүрт харилцан адилгүй [P=0.000] ялгаатай байна.

Насны бүлэг	**Хүчирхийллийн шалтгаант өвчлөлийн тэргүүлэх шалтгаан**				
	I	**II**	**III**	**IV**	**V**
0-4 n=48	Биеийн хүчээр халдах 81.2%	Тодорхойгүй 10.4%	Мохоо зүйлээр халдах 4.2%	Иртэй зүйлээр халдах 2.1%	Дүүжлэх, боймлох 2.1%
5-9 n=94	Биеийн хүчээр халдах 79.8%	Мохоо зүйлээр халдах 13.8%	Иртэй зүйлээр халдах 3.2%	Буудах 1.1%	Гал дөлөөр түлэх 1.1%
10-14 n=304	Биеийн хүчээр халдах 86.8%	Мохоо зүйлээр халдах 6.9%	Тодорхойгүй 3.0%	Иртэй зүйлээр халдах 1.6%	Өндрөөс түлхэх 0.8%
15-19 n=897	Биеийн хүчээр халдах 85.3%	Иртэй зүйлээр халдах 7.0%	Мохоо зүйлээр халдах 4.9%	Тодорхойгүй 2.1%	Тээврийн хэрэгсэлээр 0.1%
20-24 n=1678	Биеийн хүчээр халдах 81.4%	Иртэй зүйлээр халдах 10.8%	Мохоо зүйлээр халдах 4.8%	Тодорхойгүй 2.9%	Буудах 0.06%
25-29 n=2439	Биеийн хүчээр халдах 77.7%	Иртэй зүйлээр халдах 12.6%	Мохоо зүйлээр халдах 5.5%	Тодорхойгүй 3.9%	Тээврийн хэрэгсэлээр 0.2%
30-34 n=2634	Биеийн хүчээр халдах 75.1%	Иртэй зүйлээр халдах 13.6%	Мохоо зүйлээр халдах 6.0%	Тодорхойгүй 4.9%	Дүүжлэх, боймлох 0.2%
35-39 n=1958	Биеийн хүчээр халдах 74.7%	Иртэй зүйлээр халдах 13.5%	Мохоо зүйлээр халдах 6.2%	Тодорхойгүй 5.4%	Тээврийн хэрэгсэлээр 0.1%
40-44 n=1452	Биеийн хүчээр халдах 70.9%	Иртэй зүйлээр халдах 14.4%	Мохоо зүйлээр халдах 7.3%	Тодорхойгүй 6.8%	Халуун зүйлээр түлэх 0.2%
45-49 n=1077	Биеийн хүчээр халдах 72.1%	Иртэй зүйлээр халдах 14.6%	Мохоо зүйлээр халдах 7.2%	Тодорхойгүй 5.6%	Дүүжлэх, боймлох 0.2%
50-54 n=762	Биеийн хүчээр халдах 70.6%	Иртэй зүйлээр халдах 14.4%	Мохоо зүйлээр халдах 7.6%	Тодорхойгүй 6.9%	Буудах 0.3%
55-59 n=492	Биеийн хүчээр халдах 73.8%	Иртэй зүйлээр халдах 11.2%	Мохоо зүйлээр халдах 9.4%	Тодорхойгүй 5.3%	Өндрөөс түлхэх 0.2%
60-64 n=202	Биеийн хүчээр халдах 70.8%	Мохоо зүйлээр халдах 12.9%	Иртэй зүйлээр халдах 9.4%	Тодорхойгүй 5.5%	Өндрөөс түлхэх 0.9%
65-69 n=77	Биеийн хүчээр халдах 74.0%	Тодорхойгүй 9.1%	Мохоо зүйлээр халдах 7.8%	Иртэй зүйлээр халдах 7.8%	Дүүжлэх, боймлох 1.3%
70+ n=59	Биеийн хүчээр халдах 67.8%	Мохоо зүйлээр халдах 13.6%	Тодорхойгүй 11.9%	Иртэй зүйлээр халдах 6.8%	

Хүчирхийллийн шалтгаанаар гэмтэж тусламж авсан хүмүүсийн 61.8% толгойн гэмтэл, 9.1% бусад гэмтэл, 8.7% цээжний гэмтэл, 4.3% бугуй ба сарвууны гэмтэл, 4.2% тохой ба шуу гэмтсэн байна.



2020 онд хүчирхийллийн шалтгаанаар бүртгэгдсэн нийт тохиолдлын 34.8% нь шархны оноштой байна.

Хүчирхийллийн шалтгаант осол гэмтэл нийслэлд 79.5%, орон нутагт 20.5% бүртгэгдсэн бөгөөд тохиолдлын түвшин нийслэлд орон нутгаас 4.4 дахин өндөр байна.





Тухайн аймгийн 10000 хүн амд ногдох хүчирхийллийн шалтгаант өвчлөлийн тохиолдлын түвшин Дорноговь аймагт /67.9/ хамгийн өндөр, Баян-Өлгий аймагт /1.6/ хамгийн бага байна.



1.5. “АМЬД МЕХАНИК ХҮЧИНД ӨРТӨХ” ШАЛТГААНТ ШИНЭ ТОХИОЛДОЛ /W20-W49/

Амьд механик хүчинд өртөх шалтгаант өвчлөл нь 2020 оны нийт осол гэмтлийн шинэ тохиолдлын 7.7%-ийг эзэлж, осол гэмтлийн өвчлөлийн тэргүүлэх шалтгааны 5-рт орсон байна. Тус өвчлөлийн 10000 хүн амд ногдох тохиолдлын түвшин өмнөх оноос 2 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.



Амьтай механик хүчинд өрсөн шалтгаант өвчлөлийн 10 хүн тутмын 6 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй байна.



2020 онд тухайн шалтгаанаар өвчилсөн иргэдийн 53%-ийг бусад хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, хазуулж, маажуулсан тохиолдол эзэлж байгаа бол удаах байранд нохойд хазуулж гэмтэх тохиолдол элбэг байна.



Амьтай механик хүчинд өртөх шалтгааны тэргүүлэх шалтгааныг насны бүлэг тус бүрээр авч үзвэл 0-35 хүртэлх насанд хүнд санамсаргүй байдлаар түлхүүлэх, өшиглүүлэх, цохиулах, хазуулах, маажуулж гэмтэх тохиодол дийлэнхийг эзэлж байгаа бол 35-с дээш насанд нохойд хазуулсан тохиолдол тэргүүлж байна. Насны бүлэг бүрт тэргүүлэх шалтгааныг дараах хүснэгтээс харна уу.

Насны бүлэг	Амьтай механик хүчинд өртөх өвчлөлийн тэргүүлэх шалтгаан 2020				
	I	II	III	IV	V
0-4	Хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, хазуулах маажуулах 80.9%	Нохойд хазуулах 14.2%	Хөхтөн амьтанд хазуулах, өшиглүүлэх мөргүүлэх 3.2%	Бусад хүнд мөргүүлэх 0.5%	Хоргүй шавьж, үет хөлтөнд хазуулах, хатгуулах 0.5%
5-9	Нохойд хазуулах 48.7%	Хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, хазуулах маажуулах 43.1%	Хөхтөн амьтанд хазуулах, өшиглүүлэх мөргүүлэх 6.0%	Бусад хүнд мөргүүлэх 0.7%	Хоргүй шавьж, үет хөлтөнд хазуулах, хатгуулах 0.7%
10-14	Хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, хазуулах маажуулах 50.3%	Нохойд хазуулах 41.7%	Хөхтөн амьтанд хазуулах, өшиглүүлэх мөргүүлэх 6.1%	Бусад хүнд мөргүүлэх 0.9%	Хэвлээр явагчид хазуулах 0.3%
15-19	Хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, хазуулах маажуулах 64.5%	Нохойд хазуулах 24.6%	Хөхтөн амьтанд хазуулах, өшиглүүлэх мөргүүлэх 6.6%	Бусад хүнд мөргүүлэх 1.0%	Хэвлээр явагчид хазуулах 0.1%
20-24	Хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, хазуулах маажуулах 64.9%	Нохойд хазуулах 24.8%	Хөхтөн амьтанд хазуулах, өшиглүүлэх мөргүүлэх 8.3%	Бусад хүнд мөргүүлэх 1.1%	Хэвлээр явагчид хазуулах 0.5%
25-29	Хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, хазуулах маажуулах 61.8%	Нохойд хазуулах 27.8%	Хөхтөн амьтанд хазуулах, өшиглүүлэх мөргүүлэх 7.7%	Бусад хүнд мөргүүлэх 1.3%	Хоргүй шавьж, үет хөлтөнд хазуулах, хатгуулах 0.8%
30-34	Хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, хазуулах маажуулах 55.3%	Нохойд хазуулах 34.1%	Хөхтөн амьтанд хазуулах, өшиглүүлэх мөргүүлэх 7.2%	Хэвлээр явагчид хазуулах 1.8%	Бусад хүнд мөргүүлэх 0.8%
35-39	Нохойд хазуулах 44.3%	Хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, хазуулах маажуулах 41.8%	Хөхтөн амьтанд хазуулах, өшиглүүлэх мөргүүлэх 11.3%	Бусад хүнд мөргүүлэх 1.6%	Хэвлээр явагчид хазуулах 0.4%
40-44	Нохойд хазуулах 54.8%	Хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, хазуулах маажуулах 31.1%	Хөхтөн амьтанд хазуулах, өшиглүүлэх мөргүүлэх 13.0%	Бусад хүнд мөргүүлэх 0.8%	-
45-49	Нохойд хазуулах 59.5%	Хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, хазуулах маажуулах 26.0%	Хөхтөн амьтанд хазуулах, өшиглүүлэх мөргүүлэх 12.4%	Хэвлээр явагчид хазуулах 1.2%	Хоргүй шавьж, үет хөлтөнд хазуулах, хатгуулах 0.5%
50-54	Нохойд хазуулах 62.8%	Хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, хазуулах маажуулах 20.0%	Хөхтөн амьтанд хазуулах, өшиглүүлэх мөргүүлэх 14.4%	Хэвлээр явагчид хазуулах 0.5%	Хоргүй шавьж, үет хөлтөнд хазуулах, хатгуулах 0.5%
55-59	Нохойд хазуулах 65.5%	Хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, хазуулах маажуулах 20.0%	Хөхтөн амьтанд хазуулах, өшиглүүлэх мөргүүлэх 11.2%	Хэвлээр явагчид хазуулах 1.8%	Хоргүй шавьж, үет хөлтөнд хазуулах, хатгуулах 0.3%
60-64	Нохойд хазуулах 72.2%	Хөхтөн амьтанд хазуулах, өшиглүүлэх мөргүүлэх 15.3%	Хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, хазуулах маажуулах 11.2%	Хэвлээр явагчид хазуулах 0.4%	Хоргүй шавьж, үет хөлтөнд хазуулах, хатгуулах 0.4%
65-69	Нохойд хазуулах 75.6%	Хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, хазуулах маажуулах 12.2%	Хөхтөн амьтанд хазуулах, өшиглүүлэх мөргүүлэх 10.6%	Хоргүй шавьж, үет хөлтөнд хазуулах, хатгуулах 1.6%	
70+	Нохойд хазуулах 75.6%	Хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, хазуулах маажуулах 12.2%	Хөхтөн амьтанд хазуулах, өшиглүүлэх мөргүүлэх 10.6%	Хоргүй шавьж, үет хөлтөнд хазуулах, хатгуулах 1.6%	Тодорхойгүй амьд механик хүчинд өртөх 0.7%

Амьтай механик хүчинд өртөх өвчлөлийн тохиолдлын тоо болон тохиолдлын түвшин 0-4 насанд хамгийн өндөр байгаа ба нас ахих тусам буурах хандлагатай байна.



Тус өвчлөлийн 86% нь нийслэлд, 14% нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Амьтай механик хүчинд өртсөн тохиолдол 2020 онд өмнөх онтой харьцуулахад 5.2%-иар буурсан ба мөн 10000 хүн амд ногдох тохиолдлын түвшин нийслэл, орон нутаг аль алинд нь буурсан байна.



II БҮЛЭГ



2020 оны осол гэмтлийн шалтгаант нас баралтын байдалд хийсэн дүн шинжилгээ

МОНГОЛ УЛСЫН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ НАС БАРАЛТЫН БАЙДАЛ 2020 ОН

2. Ерөнхий хэсэг

2020 онд гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралтын 2736 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 3.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 10000 хүн амд ногдох нас баралтын түвшин өмнөх оноос 0.4, 2018 оноос 0.9 тохиолдлоор буурсан байна.





Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 78.1% нь эрэгтэйчүүд, 21.9% нь эмэгтэйчүүд байна.

2020 онд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмтэл хордлого, гадны шалтгаант осолд өртөж нас барсан 1460 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд түүний 82.6% эрэгтэй, 17.4% эмэгтэй хүмүүс байжээ.



Тухайн онд бүртгэгдсэн гэмтэл, хордлого, гадны шалтгаант нас баралтын түвшин өмнөх оноос 10 000 эрэгтэйд 1 тохиолдлоор буурсан бол 10 000 эмэгтэйд 0.2 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна.



2020 онд гэмтэл хордлого, гадны шалтгаанаар нас барсан нийт тохиолдлын дундаж нас 39.9, стандарт хазайлт нь 17.5 байна. Хамгийн багадаа дөнгөж төрсөн нярай гэмтэж нас барсан байгаа бол хамгийн ахмад нь 98 настай байна.

Age median	95% CI	Std.Dev	min	max	Std.Err
39.9	39.2-40.6	17.5	0	98	0.3

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын тоо эрэгтэйчүүдэд 45-49 насанд, эмэгтэйчүүдэд 40-44 насанд хамгийн их байна.



Гэмтэл хордлого гадны шалтгаант нас баралт эрэгтэйд 45-49 насанд, эмэгтэйд 40-44 насанд хамгийн өндөр бүртгэгдсэн байна. Мөн тухайн насны бүлэг дэх 10000 хүн амд ногдох осол

гэмтлийн шалтгаант нас баралтын түвшин эрэгтэй, эмэгтэйд 50-54 насанд хамгийн өндөр байна.

Насны бүлэг	Нас баралт-Эр	Нас баралтын түвшин-Эр	Нас баралт-Эм	Нас баралтын түвшин-Эм
0-4	76	3.8	150	8.0
5-9	33	1.7	53	2.9
10-14	42	2.9	63	4.6
15-19	60	5.3	90	8.2
20-24	99	8.2	117	9.9
25-29	168	12.1	194	14.0
30-34	223	14.7	264	17.3
35-39	237	19.1	301	23.6
40-44	269	24.7	328	28.5
45-49	279	29.5	325	31.4
50-54	238	31.1	309	34.7
55-59	198	30.9	253	32.3
60-64	108	26.0	136	24.8
65-69	48	21.2	63	19.3
70+	60	19.8	90	18.0

Гэмтэл хордлого гадны шалтгааны улмаас нас барсан 10 хүн тутмын 6 нь дунд боловсролтой иргэд байгаа ба 10 хүн тутмын 3 нь ажилгүй иргэд байна.

Осол гэмтлийн шалтгаанаар нас барсан хүмүүсийн ажил эрхлэлтийн байдал

2020 оны осол гэмтлийн шалтгаант нас баралтын 76% нь санамсаргүй үйлдэгдсэн бол 24% нь өөрийнхөө болон бусдын амь насанд санаатайгаар халдсан тохиолдлууд байлаа.



Гэмтэл, хордлого гадны шалтгаант нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан:

Осол гэмтлийн нас баралтын тэргүүлэх шалтгаан насны бүлэг бүрт харилцан адилгүй байна. Тухайн онд 0-4 насанд амьсгал боогдох шалтгаант осол, 5-14 насанд зам тээврийн осол, 15-34 насанд амиа хорлолт, 35-69 насанд санамаргүй хордох, хорт бодист өртөх, 70+ насанд уналтын шалтгаант нас баралт тэргүүлж байна.

-Насны бүлэг	Нас баралтын тэргүүлэх шалтгаан-2020 он				
	I	II	III	IV	V
0-4нас /n=150/	***Амьсгал боогдох 32%***	*Зам тээврийн осол 26.7%*	*Усанд живэх 11.3%*	*Түлэгдэлт 8%*	*Хордох 6.7%*
5-9нас /n=53/	*Зам тээврийн осол 30.2%*	*Хордох 15.1%*	*Усанд живэх 13.2%*	*Уналт 9.4%*	*Түлэгдэлт 9.4%*
10-14нас /n=63/	*Зам тээврийн осол 26.9%*	*Амиа хорлох 23.8%*	*Усанд живэх 15.8%*	*Уналт 9.5%*	*Хордох 9.5%*
15-19нас /n=90/	*Амиа хорлох 40%*	*Хордох 13.3%*	*Зам тээврийн осол 12.2%*	*Усанд живэх 10.0%*	*Уналт 6.7%*
20-24нас /n=117/	*Амиа хорлох 29.1%*	*Зам тээврийн осол 23.9%*	*Усанд живэх 11.9%*	*Хордох 11.9%*	*Уналт 11.1%*
25-29нас /n=194/	*Амиа хорлох 40.2%*	*Зам тээврийн осол 26.8%*	*Хордох 8.8%*	*Хүчирхийлэл 6.2%*	*Уналт 4.6%*
30-34нас /n=264/	*Амиа хорлох 25%*	*Хордох 24.6%*	*Зам тээврийн осол 16.3%*	*Байгалийн хүчинд өртөх 7.9%*	*Хүчирхийлэл 7.6%*
35-39 нас /n=301/	*Хордох 32.2%*	*Амиа хорлох 19.6%*	*Зам тээврийн осол 16.9%*	*Хүчирхийлэл 8.6%*	*Уналт 5.7%*
40-44нас /n=328/	*Хордох 34.2%*	*Амиа хорлох 19.2%*	*Зам тээврийн осол 12.8%*	*Хүчирхийлэл 7.0%*	*Уналт 7.0%*
45-49нас /n=325/	*Хордох 42.8%*	*Зам тээврийн осол 16.9%*	*Хүчирхийлэл 9.5%*	*Амиа хорлох 8.3%*	*Байгалийн хүчинд өртөх 5.2%*
50-54нас /n=309/	*Хордох 34.9%*	*Зам тээврийн осол 13.3%*	*Амиа хорлох 12.0%*	*Хүчирхийлэл 9.1%*	*Тодорхойгүй осол 7.4%*
55-59нас /n=253/	*Хордох 41.1%*	*Зам тээврийн осол 15.0%*	*Хүчирхийлэл 9.5%*	*Байгалийн хүчинд өртөх 7.1%*	*Уналт 6.3%*
60-64нас /n=136/	*Хордох 33.8%*	*Зам тээврийн осол 19.1%*	*Хүчирхийлэл 10.3%*	*Уналт 9.6%*	*Байгалийн хүчинд өртөх 7.3%*
65-69нас /n=63/	*Хордох 30.2%*	*Зам тээврийн осол 19.0%*	*Тодорхойгүй осол 14.3%*	*Байгалийн хүчинд өртөх 11.1%*	*Уналт 7.9%*
70+нас /n=90/	*Уналт 21.1%*	*Зам тээврийн осол 20.0%*	*Хордох 18.9%*	*Амиа хорлох 7.8%*	*Тодорхойгүй осол 5.6%*

2020 онд бүртгэгдсэн нийт гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралтын 28.9% нь зуны улиралд бүртгэгдсэн байна.



Нийт гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралт 7 болон 10 дугаар сард хамгийн өндөр бүртгэгдсэн байна



.

Тухайн онд бүртгэгдсэн гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралт лхагва гаригт хамгийн өндөр бүртгэгдсэн байна.



2020 онд бүртгэгдсэн нийт осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 1555 нь нийслэлд, 1181 нь орон нутагт бүртгэгдсэн ба 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин нийслэлд 10.1, орон нутагт 6.7 байна.



Орон нутагт осол гэмтлийн шалтгаант нас баралтын 1181 тохиолдол бүртгэгдсэн ба тохиолдлын тоогоор Хөвсгөл аймаг хамгийн өндөр байна. Харин тухайн аймгийн 10000 хүн амд ногдох нас баралтын түвшин Говьсүмбэр аймагт /13.4/ хамгийн өндөр, Баян-Өлгий аймагт /4.2/ хамгийн бага үзүүлэлттэй байна.



Аймаг бүрийн осол гэмтлийн нас баралтын тэргүүлэх шалтгааныг хүснэгтээс харна уу.

Харъяалал	Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан				
	I	II	III	IV	V
Архангай /n=106/	*Зам тээврийн осол 24.5%*	*Амиа хорлох 21.7%*	*Амьсгал боогдох 21.7%*	*Хордох 9.4%*	*Усанд живэх 5.7%*
Баян-Өлгий /n=46/	*Зам тээврийн осол 37.0%*	*Усанд живэх 19.6%*	*Амиа хорлох 19.6%*	*Уналт 4.3%*	*Амьд механик хүчинд өртөх 4.3%*
Баянхонгор /n=53/	*Зам тээврийн осол 37.7%*	*Амиа хорлох 22.6%*	*Хордох 13.2%*	*Түлэгдэлт 9.4%*	*Хүчирхийлэл 5.7%*
Булган /n=29/	*Усанд живэх 27.6%*	*Амиа хорлох 20.7%*	*Зам тээврийн осол 17.2%*	*Хордох 13.8%*	*Хүчирхийлэл 10.3%*
Говь-Алтай /n=44/	*Зам тээврийн осол 29.5%*	*Амиа хорлох 25.0%*	*Амьсгал боогдох 13.6%*	*Байгалийн хүчинд өртөх 9.1%*	*Уналт 6.8%*
Говьсүмбэр /n=24/	*Зам тээврийн осол 33.3%*	*Амиа хорлох 16.7%*	*Хордох 12.5%*	*Уналт 8.3%*	*Амьгүй м/х өртөх 8.3%*
Дархан-Уул /n=49/	*Хордох 55.1%*	*Уналт 16.3%*	*Түлэгдэлт6.1%*	*Амиа хорлох 6.1%*	*Зам тээврийн осол 4.1%*
Дорнод /n=59/	*Зам тээврийн осол 45.8%*	*Амиа хорлох 15.2%*	*Хордох 11.9%*	*Уналт 6.8%*	*Байгалийн хүчинд өртөх 5.1%*
Дорноговь /n=57/	*Зам тээврийн осол 28.1%*	*Амиа хорлох 22.8%*	*Хордох 21.0%*	*Амьгүй м/х өртөх 5.3%*	*Түлэгдэлт 5.3%*
Дундговь /n=39/	*Зам тээврийн осол 43.6%*	*Амиа хорлох 20.5%*	*Хордох 12.8%*	*Амьсгал боогдох 10.3%*	*Усанд живэх 5.1%*
Завхан /n=37/	*Зам тээврийн осол 45.9%*	*Амиа хорлох 16.2%*	*Уналт 10.8%*	*Хордох 8.1%*	*Түлэгдэлт 8.1%*
Орхон /n=68/	*Хордох 33.8%*	*Амиа хорлох 17.6%*	*Уналт 10.3%*	*Зам тээврийн осол 8.8%*	*Байгалийн хүчинд өртөх 8.8%*
Өвөрхангай /n=51/	*Зам тээврийн осол 33.3%*	*Амиа хорлох 19.6%*	*Хордох 17.6%*	*Хүчирхийлэл 9.8%*	*Түлэгдэлт 7.8%*
Өмнөговь /n=37/	*Зам тээврийн осол 37.8%*	*Амиа хорлох 21.6%*	*Байгалийн хүчинд өртөх 13.5%*	*Амьсгал боогдох 8.1%*	*Уналт 5.4%*
Сүхбаатар /n=59/	*Зам тээврийн осол 44.1%*	*Хордох 11.9%*	*Амиа хорлох 11.9%*	*Байгалийн хүчинд өртөх 10.2%*	*Хүчирхийлэл 6.8%*
Сэлэнгэ /n=56/	*Хордох 25.0%*	*Зам тээврийн осол 23.2%*	*Амиа хорлох 17.9%*	*Хүчирхийлэл 12.5%*	*Усанд живэх 8.9%*
Төв /n=74/	*Зам тээврийн осол 28.4%*	*Усанд живэх 20.3%*	*Хордох 13.5%*	*Амиа хорлох 13.5%*	*Байгалийн хүчинд өртөх 6.8%*
Увс /n=41/	*Зам тээврийн осол 41.5%*	*Амиа хорлох 21.9%*	*Байгалийн хүчинд өртөх 12.2%*	*Хордох 12.2%*	*Усанд живэх 7.3%*
Ховд /n=50/	*Зам тээврийн осол 44.0%*	*Амиа хорлох 20.0%*	*Усанд живэх 10.0%*	*Амьгүй м/х өртөх 6.0%*	*Хордох 6.0%*
Хэнтий /n=52/	*Амиа хорлох 30.8%*	*Усанд живэх 17.3%*	*Зам тээврийн осол 15.4%*	*Хордох 11.5%*	*Хүчирхийлэл 9.6%*
Хөвсгөл /n=150/	*Амиа хорлох 30.7%*	*Зам тээврийн осол 19.3%*	*Хордох 14.7%*	*Усанд живэх 12.7%*	*Хүчирхийлэл 6.0%*
Улаанбаатар /n=1555/	*Хордох 38.2%*	*Амиа хорлох 13.4%*	*Зам тээврийн осол 9.6,*	*Хүчирхийлэл 9.1%*	*Уналт 8.8%*

Осол гэмтлийн шалтгаант нас баралтын түвшин зүүн бүсэд хамгийн өндөр байна.



Монгол улсад 2020 онд осол гэмтлийн 1000 шинэ тохиолдол тутамд нийслэлд 12.9 тохиолдол, орон нутагт 46.7 тохиолдол нас баралтаар төгссөн байна.



Тухайн жилд тухайн шалтгаанаар бүртгэгдсэн 1000 шинэ гэмтэл тутамд үхлийн түвшин живэлт, амьсгал боох аюултай осол, амиа хорлох, санамсаргүй хордох, байгалийн хүчинд өртөх зэрэг шалтгаанууд /300.8-853.3 тохиолдол/ өндөр байна. Энэ нь усанд живсэн 1000 шинэ гэмтэл тутамд 853.3 тохиолдол нь нас баралтаар төгсөж байгааг харуулж байна.

2.1. САНАМСАРГҮЙ ХОРДОХ, ХОРТ БОДИСТ ӨРТӨХ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ /X40-X49/

Санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгааны улмаас нас барж буй тохиолдол нь Монгол улсын гэмтэл, хордлого, гадны шалтгаант нас баралтын тэргүүлэх шалтгаан болдог. 2020 онд осол гэмтлийн өвчлөл, нас баралт өмнөх оноос тодорхой хувиар буурсан боловч хордож нас барсан тохиолдол өмнөх онтой харьцуулахад 3.5%-иар өссөн үзүүлэлттэй байгаа нь анхаарал татахуйц байна. Мөн 10000 хүн тутмын 2.3 тохиолдол нь нас баралтаар төгссөн байна.



2020 оны гэмтэл, хордлого гадны шалтгаант нас баралтын 28.3%-ийг санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаант нас баралт эзэлсэн ба нийт хордож нас барсан тохиолдлын 78.5%-ийг эрэгтэйчүүд, 21.5%-ийг эмэгтэйчүүд эзэлжээ.





Санамсаргүй хордох, хорт бодист өртөж нас барах тохиолдол 45-49 насанд тохиолдлын тоогоор хамгийн их байгаа бол 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин 55-59 насанд өндөр байна. 2020 онд бүх насны бүлэгт санамсаргүй хордох, хорт бодист өртсөн тохиолдол бүртгэгдсэн байна.



Санамсаргүй хордож нас барсан тохиолдлын 63% нь дунд, 15% нь дээд, 14% нь мэргэжил техникийн, 5% нь бага боловсролтой үлдсэн 4%-д боловсролгүй байсан бол дээрх иргэдийн 42%-ийг ажилгүй, 20%-ийг ажилчин, албан хаагч, 11%-ийг тэтгэвэрийн насныхан эзэлсэн байна.





Санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаанаар нас барсан нийт тохиолдлын **99.8%** нь эмийн бус бодист хордсон байна**.**

Санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаанаар нас барсан тохиолдлыг хордсон бодисын төрлөөр авч үзвэл **спиртэнд санамсаргүй хордсон тохиолдол дангаараа 84.1%**-ийг эзэлж байна.

X45 Спиртэнд санамсаргүй хордох 84.1%

X47 Бусад хий, ууранд санамсаргүй хордох, өртөх 13.8%

X49 Бусад ба тодорхойгүй химийн ба хорт бодисоор санамсаргүй хордох, өртөх 1.7%

X44 Бусад ба тодорхойгүй эм, эмийн бэлдмэл, биологийн бодист санамсаргүй хордох, өртөх 0.3%

X48 Хортон шавьж устгах хоронд санамсаргүй хордох өртөх 0.1%

Санамсаргүй хордож нас барсан эрэгтэйчүүд өвлийн улиралд, эмэгтэйчүүд хаврын улиралд их байжээ.



2020 онд санамсаргүй хордож нас барсан тохиолдол 1-3 болон 10 саруудад их бүртгэгдсэн ба хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүд 1 сард, эмэгтэйчүүд 3 сард хамгийн их хордож нас барсан байна.



2020 хорд хордож нас барсан тохиолдлын 76.7% нь нийслэл хотод, 23.3% нь хөдөө орон нутагт бүртгэгдлээ.



Жилд нийслэлийн 10000 хүн ам тутмын 3-4 хүн, хөдөө орон нутгийн 10000 хүн ам тутмын 1 нь санамсаргүй хордож, хорт бодисд өртөж нас барж байна. Нийслэлд 2020 онд нийслэлд өмнөх оноос нас баралтын түвшин өссөн байгаа бол орон нутагт буурсан үзүүлэлттэй байна.



Өнгөрөгч оны байдлаар Монгол улс сард дунджаар 64-65, өдөрт 1-2 хүнээ хордлогын улмаас алдсан байна.



2.2 ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ /V01-V99/

Зам тээврийн ослын шалтгаант 10000 хүн амд ногдох түвшин 2020 онд буурсан үзүүлэлттэй байна.



2020 онд зам тээврийн ослоор нас барсан нийт тохиолдлын 76.7% нь эрэгтэйчүүд, 23.3% нь байна.



Зам тээврийн ослын шалтгаант нас барсан тохиолдлын тоо болон, нас баралтын түвшин 45-49 насанд хамгийн өндөр байна.





Зам тээврийн ослын шалтгаант нас баралтаар согтуурулах ундаа хэрэглэсэн үедээ нас барсан тохиолдлын тоо болон 10000 хүн амд ногдох нас баралтын түвшин 2020 онд өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

2020 оны байдлаар явган зорчигч тээврийн хэрэгсэлд мөргүүлсэн ослоор 33.5%, суудлын машинтай явж байхдаа зам тээврийн осолд өртсөн 29.4%, мөн 24.1% нь мотоциклын ослоор амь нас эрсдэж байна.

АМ ТЭЭВРИЙН ОСЛЫН НАС БАРАЛТ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТӨРЛӨӨР 2020 ОН



Зам тээврийн ослын улмаас гэмтэж бэртсэн иргэдийн дийлэнх хувь нь нийслэлд бүртгэгдсэн бол зам тээврийн шалтгаант нас баралтын хувьд 69.6% нь орон нутагт бүртгэгджээ.



Зам тээврийн ослын шалтгаант нас баралтыг гэмтлийн оношоор авч үзвэл тархины гэмтлийн улмаас нас барсан тохиолдол дийлэнх хувийг эзэлж байна.



Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын 35.3% нь зун, 24.9% нь намар, 25.5% нь хавар, 14.3% нь өвөл хамгийн бага бүртгэгдсэн байна.



Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын тохиолдол Хөвсгөл аймагт хамгийн их бүртгэгдсэн бол тухайн газар нутгийн 10000 хүн амд ногдох зам тээврийн ослын нас баралтын түвшин Дундговь аймагт өндөр байна. Харин зам тээврийн ослын нас баралтын түвшин Дархан-Уул аймагт хамгийн бага бүртгэгджээ.



2.3. “АМИА ХОРЛОХ” ШАЛТГААНТ НАС БАРАЛТ /X60-X84/

Монгол улсад 2020 онд амиа хорлож нас барсан 451 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 1.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тухайн онд санаатайгаар өөртөө гэмтэл учруулах шалтгаант нас баралтын түвшин 10000 хүн ам тутамд 1.4 промилл байна.



Сүүлийн 3 жил санаатайгаар өөртөө гэмтэл учруулах шалтгаант нас баралтын түвшин он бүрт ижил 1.4 тохиолдол байгаа бол 1000 шинэ гэмтэл тутам дахь үхлийн түвшин өмнөх оноос 24.1 тохиолдлоор өссөн байна.



Амиа хорлож нас барсан нийт тохиолдлын 85% эрэгтэй, 15% эмэгтэй хүмүүс байна. Амиа хорлож нас барах тохиолдол эрэгтэйчүүдэд өндөр байна.

Амиа хорлох шалтгаант нас баралтын түвшин эрэгтэйд 10000 хүн амд 2.4 тохиолдол, эмэгтэйд 0.4 тохиолдол байна. Нас баралтын түвшин өмнөх оноос эрэгтэйд 0.1 тохиолдлоор буурсан байгаа бол эмэгтэйд 0.1 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна.



Амиа хорлож нас барсан тохиолдол эрэгтэйд 25-29 насанд, эмэгтэйд 15-19 насанд их бүртгэгдсэн байна.



Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин эрэгтэйд 40-44 насанд /5.1/, эмэгтэйд 15-19 насанд /1.2/ бусад наснаас өндөр байна.



Амиа хорлож нас барсан тохиолдлын тэргүүлэх 5 шалтгаан:

1. Өөрийгөө дүүжлэх, боймлох 88.7%
2. Өөрийгөө буугаар буудах 4.4%
3. Иртэй зүйлээр өөрийгөө гэмтээх 2.9%
4. Өндөрөөс үсрэх 0.9%
5. Спирт, бусад бодис 0.7%

Амиа хорлож нас барсан тохиолдлын тэргүүлэх 5 шалтгааныг насны бүлэг бүрт тооцоход аль ч насанд өөрийгөө дүүжлэх, боох шалтгаан 1-рт байна.

Насны бүлэг	Тэргүүлэх 5 шалтгаан				
	I	II	III	IV	V
5-9 n=2	Өөрийгөө дүүжлэх, боох 100%				
10-14 n=15	Өөрийгөө дүүжлэх, боох 93.3%	Тодорхойгүй 6.7%			
15-19 n=36	Өөрийгөө дүүжлэх, боох 83.3%	Эмийн бодисд хордох 5.6%	Өөрийгөө буугаар буудах 5.6%	Өндөөс үсрэх 5.6%	
20-24 n=34	Өөрийгөө дүүжлэх, боох 97.1%	Өөрийгөө буугаар буудах 2.9%			
25-29 n=78	Өөрийгөө дүүжлэх, боох 85.9%	Иртэй зүйлээр 5.1%	Өөрийгөө буугаар буудах 5.1%	Эмийн бодисд хордох 1.3%	Өндөөс үсрэх 1.3%
30-34 n=66	Өөрийгөө дүүжлэх, боох 92.4%	Өөрийгөө буугаар буудах 6.1%	Спирт, бусад бодисд хордох 1.5%		
35-39 n=59	Өөрийгөө дүүжлэх, боох 91.5%	Өөрийгөө буугаар буудах 3.4%	Зам тээврийн осол 1.7%	Өндөөс үсрэх 1.7%	Тодорхойгүй 1.7%
40-44 n=63	Өөрийгөө дүүжлэх, боох 79.4%	Иртэй зүйлээр 11.1%	Усанд живэх 3.2%	Өөрийгөө буугаар буудах 3.2%	Спирт, бусад бодисд хордох 1.6%
45-49 n=27	Өөрийгөө дүүжлэх, боох 92.6%	Иртэй зүйлээр 3.7%	Өөрийгөө буугаар буудах 3.7%		
50-54 n=37	Өөрийгөө дүүжлэх, боох 97.3%	Гал, дөл, ууранд түлэх 2.7%			
55-59 n=15	Өөрийгөө дүүжлэх, боох 93.3%	Өөрийгөө буугаар буудах 6.7%			
60-64 n=8	Өөрийгөө дүүжлэх, боох 87.5%	Өөрийгөө буугаар буудах 12.5%			
65-69 n=4	Өөрийгөө дүүжлэх, боох 25%	Өндөөс үсрэх 25%	Спирт, бусад бодисд хордох 25%	Өөрийгөө буугаар буудах 25%	
70+ n=7	Өөрийгөө дүүжлэх, боох 85.7%	Өөрийгөө буугаар буудах 14.3%			

2020 онд амиа хорлож нас барсан нийт тохиолдлын 28% буюу хамгийн их тохиолдол хавар бүртгэгдсэн байна. Зун 27%, өвөл 25% бүртгэгдсэн бол хамгийн бага хувь нь намар 20% бүртгэгдсэн байна.



Тухайн жил амиа хорлож нас барсан тохиолдлын 10.6% нь 5-р сард хамгийн их 5.8% буюу хамгийн бага нь 12 сард бүртгэгдсэн байна.



Амиа хорлож нас барсан тохиолдол даваа, лхагва, баасан гаригт өндөр бүртгэгдсэн байна.



Тухайн онд амиа хорлож нас барсан тохиолдлын 65.9% нь амиа хорлоход хүргэсэн хэлбэр тодорхойгүй байна.

2020 онд амиа хорлож нас барсан нийт тохиолдлын 54% орон нутагт, 46% нь нийслэлд бүртгэгдсэн байна.

10 000 хүн тутамд нас баралтын түвшин нийслэл, орон нутагт ялгаагүй 1.4 тохиолдол байна. Харин амиа хорлохыг завдсан 1000 шинэ гэмтэл тутамд нийслэлд 294 тохиолдол, орон нутагт 670 тохиолдол байна. Орон нутагт амиа хорлох шалтгаант осол гэмтлийн 1000 шинэ тохиолдол тутам 670 нь нас баралтаар төгсөж байна.



Амиа хорлож нас барсан тохиолдол Хөвсгөл аймагт хамгийн их бүртгэгдсэн бөгөөд 10 000 хүн ам тутамд нас баралтын түвшин 3.4 тохиолдол байгаа нь бусад аймгуудаас өндөр байна. Амиа хорлолтын шалтгаант нас баралтын түвшин Дархан-Уул аймагт хамгийн бага /0.3 тохиолдол/ байна.

2020 онд амиа хорлож нас барсан нийт тохиолдлын 45% нь согтууруулах ундаа хэрэглэсэн байна.



2.4. “ХҮЧИРХИЙЛЭЛ”-ИЙН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ /X85-Y09/

Монгол улсад 2020 онд осол гэмтлийн шалтгаанаар нас барсан 2736 тохиолдол бүртгэгдсэний 7.6% буюу 207 нь хүчирхийллийн шалтгаант нас баралт байна. Энэ нь өмнөх оноос 1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тухайн онд хүчирхийллийн шалтгаант нас баралтын түвшин 10000 хүн ам тутамд 0.6 тохиолдол байна.



2020 онд бүртгэгдсэн хүчирхийллийн шалтгаант нас баралтын тохиолдол өмнөх оноос буурсан байгаа боловч хүчирхийллийн шалтгаант 1000 гэмтэл тутам дахь үхлийн түвшин 14.6 тохиолдол буюу өссөн үзүүлэлттэй байна.





Хүчирхийллийн шалтгаант 207 нас баралтын 79% нь эрэгтэй, 21% нь эмэгтэй байна.

Хүчирхийллийн шалтгаант нас баралтын түвшин эрэгтэйд 0.1 тохиолдлоор буурсан байгаа бол эмэгтэйд 0.1 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна. Тухайн шалтгаант нас баралт эрэгтэйчүүдэд өндөр байна.



2020 онд хүчирхийлэлд өртөж нас барсан тохиолдол эрэгтэйд 45-49 насанд, эмэгтэйд 50-59 насанд бусад наснаас өндөр бүртгэгдсэн байна.



Хүчирхийллийн шалтгаант нас баралтын түвшин эрэгтэйд 60-64 насанд /2.9 тохиолдол/, эмэгтэйд 55-59 насанд /0.9 тохиолдол/ бусад наснаас өндөр байна.



Хүчирхийллийн шалтгаант нас баралтын тэргүүлэх шалтгаан:

1. Мохоо зүйлээр бусдад халдах 35.7%
2. Иртэй зүйлээр бусдад халдах 34.3%
3. Биеийн хүчээр бусдад халдах 19.3%
4. Бусдыг дүүжлэх боймлох 3.9%
5. Бусдыг буудах 2.9%

2020 онд хүчирхийллийн шалтгаанаар нас барсан нийт тохиолдлын 63.8% ийн хүчирхийлэгч, хохирогч хоорондын холбоо тодорхойгүй байна.



Нийт хүчирхийллийн шалтгаант нас баралтын 60% буюу 124 нь согтууруулах удаа хэрэглэсэн үедээ бусдын халдлагад өртжээ. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ дайралт халдлагад өртөж нас барсан тохиолдлын 80% буюу 99 нь эрэгтэй хүмүүс байна.

2020 онд хүчирхийллийн шалтгаант нийт тохиолдлын 32% буюу хамгийн их тохиолдол хавар бүртгэгдсэн байна. Зун 24%, намар 24% бүртгэгдсэн бол хамгийн бага хувь нь өвөл 20% бүртгэгдсэн байна.



Тухайн жил бусдын халдлагад өртөж нас барсан тохиолдлын 12.1% буюу хамгийн их нь 4-р сард, 4.4% буюу хамгийн бага нь 2 сард бүртгэгдсэн байна.



Хүчирхийллийн шалтгаант нас баралт Лхагва, Баасан гаригуудад өндөр бүртгэгдсэн байна.



Хүчирхийллийн шалтгаант нас баралтын нийт тохиолдлын 68% нь нийслэлд, 32% нь орон нутагт бүртгэгдсэн байна.



10 000 хүн тутамд нас баралтын түвшин нийслэлд 0.9 тохиолдол, орон нутагт 0.4 тохиолдол байна. Харин хүчирхийллийн шалтгаант 1000 шинэ гэмтэл тутамд нийслэлд 12.5 тохиолдол, орон нутагт 22.7 тохиолдол байна. Орон нутагт бусдын халдагад өртсөн 1000 тохиолдол бүрийн 22.7 тохиолдол нь нас баралтаар төгсөж байна.



Бусдад хорлогдож нас барсан тохиолдол Хөвсгөл, Сэлэнгэ аймагт хамгийн их бүртгэгдсэн бөгөөд 10 000 хүн тутамд нас баралтын түвшин мөн Хэнтий аймагт 1.0 тохиолдол байгаа нь бусад аймгуудаас өндөр байна.



2.5. УНАЛТЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТЫН ТОХИОЛДОЛ /W00-W19/

Улсын хэмжээнд 2020 онд 2736 гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралт бүртгэгдэж үүний 185 тохиолдол буюу 6.8%-ийг уналтын шалтгаант нас баралт эзэлж, осол гэмтлийн нас баралтын 5-р байранд орсон байна. Мөн 2020 онд унаж гэмтсэний улмаас нас барсан хүмүүсийн 73.0%-ийг эрэгтэйчүүд эзэлжээ.





Уналтын шалтгаант нас баралт 2020 онд өмнөх оноос 0.5%-иар буурсан бөгөөд 10000 хүн амд ногдох нас баралтын түвшин 0.6 байна.



Уналтын шалтгаант нас баралтыг насны бүлгээр авч үзэхэд 40-44 насанд тохиолдлын тоо их байгаа бол нас баралтын түвшин 70+ насанд өндөр байна.



Унаж нас барсан тохиолдлыг насны бүлгээр авч үзвэл 0-65 хүртэлх насанд барилга, байгууламжаас ойчих /W13/ гэмтэл тэргүүлсэн байгаа бол 65-69 насанд нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих /W17/, 70-с дээш насанд нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унаж /W01/ нас барсан тохиолдол хамгийн их хувийг эзэлснээрээ ялгаатай байна.

Насны бүлэг	Уналтын шалтгаант өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, насны бүлгээр 2020				
	I	II	III	IV	V
0-4	Барилга, байгууламжаас ойчих 66.7%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 16.7%	Нэг түвшин дээр ойчих бусад гэмтэл 16.7%	-	-
5-9	Барилга, байгууламжаас ойчих 60.0%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 20.0%	Тодорхойгүй уналт 20.0%	-	-
10-14	Барилга, байгууламжаас ойчих 50.0%	Хад цохионоос ойчих 33.3%	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 16.7%	-	-
15-19	Барилга, байгууламжаас ойчих 83.3%	Хад цохионоос ойчих 16.7%	-	-	-
20-24	Барилга, байгууламжаас ойчих 69.2%	Шат гишгүүрээс ойчих 15.4%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 7.7%	Тодорхойгүй уналт 7.7%	-
25-29	Барилга, байгууламжаас ойчих 44.4%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 11.1%	Хад цохионоос ойчих 11.1%	Модноос ойчих 11.1%	Шат гишгүүрээс ойчих 11.1%
30-34	Барилга, байгууламжаас ойчих 72.2%	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 11.1%	Шат гишгүүрээс ойчих 5.6%	Модноос ойчих 5.6%	Тодорхойгүй уналт 5.6%
35-39	Барилга, байгууламжаас ойчих 70.6%	Хад цохионоос ойчих 11.8%	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 5.9%	Барилгын шатнаас ойчих 5.9%	Тодорхойгүй уналт 5.9%
40-44	Барилга, байгууламжаас ойчих 43.5%	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 21.7%	Шат гишгүүрээс ойчих 8.7%	Тодорхойгүй уналт 8.7%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 4.3%
45-49	Барилга, байгууламжаас ойчих 33.3%	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 20.0%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 20.0%	Нэг түвшин дээр ойчих бусад гэмтэл 6.7%	Шат гишгүүрээс ойчих 6.7%
50-54	Барилга, байгууламжаас ойчих 35.7%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 35.7%	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 14.3%	Шат гишгүүрээс ойчих 14.3%	-
55-59	Барилга, байгууламжаас ойчих 31.2%	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 18.7%	Шат гишгүүрээс ойчих 12.5%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 6.2%	Барилгын шатнаас ойчих 6.2%
60-64	Барилга, байгууламжаас ойчих 23.0%	Шат гишгүүрээс ойчих 23.0%	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 15.4%	Тодорхойгүй уналт 15.3%	Нэг түвшин дээр ойчих бусад гэмтэл 7.7%
65-69	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 40.0%	Шат гишгүүрээс ойчих 20.0%	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 20.0%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 20.0%	-
70+	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 52.6%	Барилга, байгууламжаас ойчих 26.3%	Орноос ойчих 5.3%	Сандлаас ойчих 5.3%	Шат гишгүүрээс ойчих 5.3%

2020 оны уналтын шалтгаант нас баралтын 1-рт барилга, байгууламжаас унах 46.5% /W13/, 2-рт нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдэрч унах 16.7% /W01/, 3-рт нэг түвшинээс өөр түвшинрүү унах 8.6% /W17/ шалтгаан орсон байна.

ӨОУА-10	Уналтын шалтгаант нас баралт	Тохиолдлын тоо /2020/	Хувь
W00	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах	3	1.6
W01	Нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдрэх	31	16.7
W02	Тэшүүр, цананаас	-	-
W03	Хүнтэй мөргөлдөх,түлхэгдэх	1	0.5
W04	Хүнээр зөөлгүүлэх, түшин явах үед	-	-
W05	Тахир дутуу хүний тэргэнцэрээс	-	-
W06	Орноос ойчих	2	1.1
W07	Сандлаас унах	1	0.5
W08	Бусад тавилгаас ойчих	-	-
W09	Тоглоом ба спортын талбай	-	-
W10	Шат гишгүүрээс ойчих	15	8.1
W11	Зөөврийн шатнаас ойчих	-	-
W12	Барилгын шатнаас ойчих	2	1.1
W13	Барилга, байгууламжаас ойчих	86	46.5
W14	Модноос ойчих	4	2.2
W15	Хад цохионоос ойчих	6	3.2
W16	Ус руу шумбаж үсэрч, живэлгүй гэмтэх	1	0.5
W17	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих	16	8.6
W18	Нэг түвшин дээр ойчих бусад гэмтэл	7	3.8
W19	Тодорхойгүй уналт	10	5.4

Унаж гэмтсэний улмаас нас барсан тохиолдол зуны улиралд хамгийн их байжээ.



Уналтын шалтгаант нас баралтын 73.5% нь нийслэлд, 26.5% нь хөдөө орон нутагт бүртгэгдсэн байна. Тухайн газар нутгийн 10000 хүн амд ногдох тохиолдлын түвшин өмнөх онтой харьцуулахад нийслэл орон нутаг аль алинд нь 2 тохиолдлоор буурсан байна.



III БҮЛЭГ

Харилцагч эрүүл мэндийн байгууллагуудын тандалтын мэдээ, тайлангийн үнэлгээ

Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын бүртгэл, цахим мэдээний сан, сарын мэдээ, жилийн эцсийн тайлантай холбоотой анхаарах зүйлс, нийтлэг гарч буй хүндрэл, алдааны тухай

3.1. Харилцагч эрүүл мэндийн байгууллагуудын 2020 оны Осол гэмтлийн тандалтын тайлан хамгаалсан үнэлгээ

Үнэлгээний тайлбар:

2020 оны “Осол гэмтэл, гадны шалтгааны үр дагавар”-ын тайланг хүлээн авахдаа харилцагч эрүүл мэндийн байгууллагуудыг 6 үзүүлэлтээр үнэлсэн. Үүнд:

1. Цахим тайлангийн үнэлгээг Hinfo V3.0 программаас бодуулсан ЭМТ-313.1, ЭМТ-313.2, ЭМТ-313.4 тайлангуудыг сарын мэдээтэй тулган үнэлсэн.
2. Нас баралтын мэдээ болон бааз гэсэн үнэлгээг сар бүр мэдээллэж байсан гадны шалтгаант нас баралт нь Hinfo V3.0 программын АМ-7 -оос экспортолсон бааз болон ЭМХТөвийн мэдээтэй таарч буй байдлаар үнэлсэн.
3. Стационарын баазад өгсөн үнэлгээг өөрийн эмнэлэгт осол гэмтлийн шалтгаанаар хэвтэн эмчлүүлсэн өвчтөний мэдээллийг цахимаар илгээсэн байдлаар үнэлсэн.
4. Сарын мэдээг хугацаандаа өгсөн байдлыг сар бүрийн 5-ны дотор мэдээлсэн бүх сарыг 12-т хуваан 100-аар үржүүлэн үнэлсэн.
5. Сарын мэдээ, бааз, ЭМХТөвийн мэдээ 3-н тохироог үнэлэхдээ ЭМХТөв, НЭМГазарт мэдээллэж байсан осол гэмтлийн мэдээ нь тандалтын мэдээтэй таарч буй эсэхээр үнэлсэн.
6. Мэдээний сангийн алдааг “Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас” маягтын асуумж бүрээр үнэлсэн.

Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүдийн үнэлгээний хуудас

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Үнэлгээний төрөл							
		ЭМТ 313.1 ЭМТ 313.2 ЭМТ 502 маягтуудаар бодогдсон тайлан сарын мэдээний нэгтгэлтэй таарсан	Тайлан зааврын дагуу үнэн, зөв бодуулсан байдал	Тайлангаа хугацаандаа өгсөн	Стационарийн бааз, логикийн зөрүүгүй	Сарын мэдээг хугацаандаа өгсөн байдал	Сарын мэдээ, бааз, ЭМХТөвийн мэдээ 3-н тохироо	Мэдээний сангийн алдаа	Дүн /%/
		26 оноо	10 оноо	10 оноо	10 оноо	12 оноо	12 оноо	20 оноо	100 оноо
1	УНТЭ	26	10	10	10	11	12	19	**98%**
2	УХТЭ	26	10	10	10	12	12	18	**98%**
3	УГТЭ	26	10	10	10	12	11	19	**98%**
4	ЭХЭМҮТ	26	10	10	10	11	12	19	**98%**
5	ГССҮТ	26	10	10	10	12	12	19	**99%**
6	СЭМҮТ	26	10	10	10	12	11	19	**98%**
7	ШШҮТ	26	10	9	-	8	12	15	**90%**

Орон нутгийн ЭМГазруудын үнэлгээний хуудас

№	Аймгийн нэр	Үнэлгээний төрөл							
		ЭМТ 313.1 ЭМТ 313.2 ЭМТ 502 маягтуудаар бодогдсон тайлан сарын мэдээний нэгтгэлтэй	Тайлангийн зааврын дагуу үнэн, зөв бодуулсан байдал	Тайлангаа хугацаандаа өгсөн	Стационарийн бааз, логикийн зөрүүгүй	Сарын мэдээг хугацаандаа өгсөн байдал	Сарын мэдээ, бааз, ЭМХТевийн мэдээ 3-н тохироо	Мэдээний сангийн алдаа	Дүн /%/
		26 оноо	10 оноо	10 оноо	10 оноо	12 оноо	12 оноо	20 оноо	100 оноо
1	Архангай	26	10	10	10	12	12	17	**97%**
2	Баян-Өлгий	26	10	9	10	11	12	13	**91%**
3	Баянхонгор	26	10	10	10	12	12	16	**96%**
4	Булган	26	10	10	10	7	11	18	**92%**
5	Говь-Алтай	26	10	9	10	12	12	13	**92%**
6	Говьсүмбэр	26	10	10	10	11	11	15	**93%**
7	Дархан-Уул	26	10	10	10	12	12	18	**98%**
8	Дорноговь	26	10	10	10	12	12	16	**96%**
9	Дорнод	26	10	10	10	12	12	17	**97%**
10	Дундговь	26	10	10	10	12	11	16	**95%**
11	Завхан	26	10	9	10	6	10	14	**85%**
12	Орхон	26	10	10	10	12	12	18	**98%**
13	Өвөрхангай	26	10	10	10	10	12	16	**94%**
14	Өмнөговь	26	10	10	10	12	12	18	**98%**
15	Сүхбаатар	26	10	9	10	12	12	15	**94%**
16	Сэлэнгэ	26	10	10	10	11	11	18	**96%**
17	Төв	26	10	9	10	8	10	17	**90%**
18	Увс	26	10	10	10	12	12	18	**98%**
19	Ховд	26	10	9	10	7	12	17	**91%**
20	Хөвсгөл	26	10	6	10	12	12	14	**90%**
21	Хэнтий	26	10	8	10	12	12	14	**92%**

НЭМГазрын харъяа эмнэлгүүдийн үнэлгээний хуудас

№	Аймгийн нэр	Үнэлгээний төрөл							
		ЭМТ 313.1 ЭМТ 313.2 ЭМТ 502 маягтуудаар бодогдсон тайлан сарын мэдээний нэгтгэлтэй	Тайлангийн зааврын дагуу үнэн, зөв бодуулсан байдал	Тайлангаа хугацаандаа өгсөн	Стационарийн бааз, логикийн зөрүүгүй	Сарын мэдээг хугацаандаа өгсөн байдал	Сарын мэдээ, бааз, ЭМХТөвийн мэдээ 3-н тохироо	Мэдээний сангийн алдаа	**Дүн /%/**
		26 оноо	10 оноо	10 оноо	10 оноо	12 оноо	12 оноо	20 оноо	**100 оноо**
1	Хүүхдийн төв сувилал	26	10	10	10	12	12	20	**100%**
2	Наркологи	26	10	10	10	11	12	19	**99%**
3	ЦТЭ	24	10	8	10	11	10	20	**93%**
4	ТЗНЭ	24	10	8	10	11	10	20	**93%**
5	ТТАХНЭ	26	10	10	10	12	10	19	**97%**
6	МЯСЭ	26	10	8	10	11	11	20	**96%**
7	БГДЭМТ	26	10	9	10	12	12	19	**98%**
8	БЗДНЭ	26	10	8	10	12	12	15	**93%**
9	БЗДЭМТ	26	10	9	10	10	12	17	94%
10	СХДЭМТ	26	10	10	10	6	12	18	**92%**
11	СБДНЭ	26	8	9	9	1	10	18	**81%**
12	СБДЭМТ	26	10	9	10	11	12	20	**98%**
13	ХУДНЭ, ЭМТ	26	10	10	10	12	10	18	**98%**
14	ЧДНЭ, ЭМТ	26	10	10	10	11	12	19	**98%**
15	Налайх	26	10	10	10	7	12	15	**90%**
16	Багануур	26	10	9	10	11	12	17	**95%**
17	Багахангай	26	10	10	10	12	10	17	**97%**
18	Жаргалант	26	10	9	9	10	10	20	**94%**
19	Гачуурт	26	10	10	10	11	11	19	**97%**
20	Хонхор	26	10	10	10	11	11	16	**94%**
21	Туул	26	10	9	10	12	11	17	**95%**
22	Мөнгөнгүүр	26	10	10	10	12	11	14	**93%**
23	Интермед	26	10	10	10	12	11	19	**98%**

Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын мэдээний санд сар бүр гарч буй нийтлэг алдааны тухай

ГССҮТөвийн СТСАлбаны мэргэжилтнүүд эмнэлгүүдийн осол гэмтлийн өвчлөл, нас баралтын сарын мэдээг цахимаар хүлээн авч Hinfo V3.0 программ дахь бүртгэлтэй тулган, бүртгэлийн болон логик алдаа байгаа тохиолдолд тухай бүрт нь хариу илгээдэг тул очсон и-мэйл-н дагуу мэдээний сангийн алдаагаа сар бүрдээ хянаж хэвшинэ үү!

/Тайлангийн үеэр эмнэлэг бүрт биечлэн дэлгэрэнгүй тайлбарлаж зааж өгсөн ба дараах зүйлсийг анхан шатанд үзлэг хийн маягт хөтөлж буй эмч нартаа анхааруулна уу/

1. Регистрийн дугаар буруу орсон тохиолдолд нас, хүйс буруу бүртгэгдэх тохиолдол байна. Жишээ нь: 100-аас дээш настай хүмүүсийн ихэнх нь регистрийн дугаар буруу оруулсантай холбоотойгоор нас нь 100-р нэмэгдсэн буюу хүүхдүүд байх нь элбэг байдаг. Тиймээс 100-аас дээш настай хүмүүсийн бүртгэлээ үнэн эсэхийг нягталж хэвшинэ үү
2. 15 хүртэлх насны хүүхдүүд дунд, дээд боловсролтой болон аль нэг газар ажил эрхэлдэг гэсэн сонголт хийгдсэн байгаа эсэхийг шалгаж хэвших. Учир нь 5 настай хүүхдэд дээд боловсролтой, мөн 8 настай хүүхдэд ажил эрхэлдэг гэх мэт логикийн хувьд алдаатай бүртгэлүүд элбэг тохиолддог. Энэ нь хувь хүний мэдээллийн хэсгийг сайн шалгаагүйтэй холбоотой. Түүнчлэн хүүхэд байх үед нь бүртгэсэн мэдээллээ шинэчилдэггүйтэй холбоотойгоор насанд хүрсэн хүмүүсийн албан тушаал 0-15 насны хүүхэд гэж бүртгэгдэж байна.
3. Согтууруулах ундаа хэрэглэсэн гэж мэдээлсэн тохиолдлууд дунд насанд хүрээгүй хүүхэд байгаа тохиолдолд үнэн эсэхийг заавал нягталсны дараа бүртгэх, мэдээлэх
4. Мансууруулах бодис хэрэглэсэн гэж сонгогдсон тохиолдолд заавал эргэн шалгах, лавлах
5. Зам тээврийн ослын шалтгааны гэмтлийн үед V үсэгний арын тоо нь тухайн гэмтсэн хүний ямар тээврийн хэрэгслээр явж байсныг зааж байгаа бөгөөд энэ нь арагш задарсан асуултын 1-р асуулттай таарч байх ёстой. Жишээ нь:
   V тэмдэглэгээний ард 1 гэсэн болон эхний асуултад унадаг дугуйг сонгоно гэсэн үг юм. Явган зорчигч бол V үсэгний ард 0 байна гэх мэт.
6. Зам тээврийн ослын шалтгааны гэмтлийн үед V үсэгний арын 2-р тоо нь тухайн гэмтсэн хүн ямар тээврийн хэрэгсэлтэй мөргөлдсөнийг зааж байгаа ба энэ нь арагш задарсан асуултын 3-р асуулттай таарч байх ёстой. Жишээ нь:
   Суудлын машинтай явж байсан хүн шон мөргөөд түүнээсээ болж гэмтсэн бол 3 дахь асуултанд хөдөлгөөнгүй зүйл мөргөсөн гэдгийг сонгох ба V47-р кодолно.
7. Морь болон тэмээнээс унаж гэмтсэн тохиолдлыг ердийн хөсөгнөөс унасан буюу V80-р кодлох ба 2-р эгнээний асуултанд хариулахдаа жолооч, зорчигч гэх мэт сонголт огт хийхгүй. Зөвхөн уралдааны морь унаач эсвэл энгийн морь унаач гэсэн сонголтыг хийнэ.
8. Хүчирхийлэл буюу өвчний олон улсын ангиллаар Дайралт, халдлага X85-Y09-өөр кодлогддог шалтгаанд биеийн болон бэлгийн бүх төрлийн санаатайгаар нэгнээ гэмтээсэн тохиолдлууд орохыг анхаарна уу. Өөрөөр хэлбэл биеэрээ болон мод, чулуу, шил, хутга гэх мэт зэвсэг ашиглан зодолдсон тохиолдлууд орно. Зарим тохиолдолд бусдад зодуулсан хүмүүсийн гэмтлийн шалтгааныг W50-аар буруу кодолсон байна. Өвчний олон улсын ангиллаар W50 нь бусад хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, мушгиулах, хазуулах, маажуулах тохиолдлууд орох ба энэ нь зөвхөн санамсаргүй гэмтээсэн тохиолдолд л сонгогдох код гэдгийг анхаарна уу. Жишээ нь:
   Тоглож байгаад санаандгүй нэгнээ түлхэж унагаад гэмтээсэн, сагс тоглож байгаад санаандгүй маажуулсан, гараа эргүүлж байсан хүнд санаандгүй цохигдох зэрэг нь W50

ангилалд орно. Харин санаатайгаар цохисон, маажсан, өшиглөсөн бол хүчирхийлэл гэсэн ангилалд оруулна. Мөн яг юу ашиглан зодсоныг нь тусгай тэмдэглэл хэсэгт нэмэлт тайлбар бичнэ үү!

9. Түүнчлэн хүчирхийллийг кодлохдоо хэрэглэсэн арга зүйлээс нь хамаарч ялгаатай кодолдог болохыг анхаарна уу. Жишээ нь:
   Санаатайгаар боосон бол Х91-р, хутгалсан бол Х99-р, мод чулуугаар цохисон бол У00-р, гар хөлөөрөө цохиж зодсон бол У04-р кодлоно.
10. Түлэнхийн шалгаанаар /W85-X19/ тусламж асан хүмүүст Т20-Т32-н хооронд онош тавих ёстой. Бүртгэгдсэн түлэнхийн тохиолдлууд дунд S-тэй оношууд байгааг анхаарна уу. Түүнчлэн яг юунд хэрхэн түлэгдсэн тухай “тусгай тэмдэглэл” багананд дэлгэрүүлэн бичнэ үү! Жишээ нь: халуун тогоотой зүйлд түлэгдсэн тохиолдлыг заавал тодруулан бичнэ үү
11. “Тусгай тэмдэглэл” хэсэгт нэмэлт тайлбар шаардлагатай тохиолдлуудыг тэмдэглэх ба тухайн мөчид юу болсоныг тусгай тэмдэглэл хэсэгт нэмэлтээр бичнэ. Ингэснээр кодолж чадахгүй байгаа болон эргэлзээтэй тохиолдлуудаа тухай бүрт нь шийдвэрлэх ач холбогдолтой.

НИЙТИЙГ ХАМАРСАН ОСОЛ ГЭМТЭЛ ГАРСАН ТОХИОЛДОЛД ОСОЛ ГЭМТЛИЙН ТАНДАЛТЫН АЛБАНД ЯАРАЛТАЙ МЭДЭЭЛЖ БАЙХЫГ АНХААРУУЛЖ БАЙНА.

Жишээ нь: гэр бүлээрээ болон олноороо явж байгаад зам тээврийн осолд орох, ажлын байр, гэр, байшин шатаж олон хүн түлэгдэх, байгалийн гамшиг тохиолдох, барилга байшин үйлдвэр уурхай нурах гэх мэтээс болж 4 болон түүнээс олон хүн 1 дор гэмтсэн, нас барсан тохиолдлуудыг сарын мэдээний хугацааг хүлээлгүйгээр тухай бүрт gemteltandalt@gmail.com хаягаар болон 88765005, 80081049 дугаарт мэдээлнэ үү!

Та бүхний мэдээлж буй “Осол гэмтлийн тохиолдол” бүрийн үнэн, зөв байдал нь цаашид осол гэмтлээс урьдчилан сэргийлэх нотолгоонд суурилсан үйл ажиллагаанд хэрэглэгдэх мэдээллийн нэгж болдогийг онцгой анхааран эмч мэргэжилтнүүдээ зөвлөмж арга зүйгээр ханган ажиллана уу!